

Аравтын бүрэн ангиллын код

Нууцын зэрэглэл

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуСс-2020/4

ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБОО

**“ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ
СУДЛАЛ: БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН
САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ, ШИНЭ ЧИГ
ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ”**

Суурь судалгааны төслийн тайлан
2020-2022

Сэдвийн удирдагч:

С.Чулуун-Академич

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

БШУЯ

Тайлан өмчлөгч:

Олон Улсын Монгол Судлалын
Холбоо

СТӨ-9 давхар, А.Амар гудамж,
Сүхбаатар дүүрэг,
14500 Улаанбаатар

УЛААНБААТАР
2023

ГАРЧИГ

УДИРТГАЛ.....4-6

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛААЧДЫН МЭДЭЭЛЛИЙН САН ХӨМРӨГ,
СУДАЛГААНЫ БААЗ**

- 1.1. АМАРМЭНДИЙН
ПУНСАГ.....7**
- 1.2. ГААДАМБЫН
БИЛГҮҮДЭЙ.....7**
- 1.3. ГАЛИНДЭВИЙН
МЯГМАРСАМБУУ.....8**
- 1.4. ДАЛАНТАЙН
ЦЭРЭНСОДНОМ.....9**
- 1.5. ДАМДИНСҮРЭНГИЙН
ЦЭВЭЭНДОРЖ.....10**

1.6. ДИЙМААЖАВЫН ЭРДЭНЭБААТАР.....	11
1.7. ДОЖООГИЙН ЦЭДЭВ.....	12
1.8. ДОМИЙН ТӨМӨРТӨГӨӨ.....	13
1.9. ДОРЖПАЛАМЫН СУМЪЯА.....	14
1.10. ЖИГЖИДИЙН БОЛДБААТАР.....	14
1.11. ЖУРЫН БАЯНСАН.....	15
1.12. ЛУВСАНВАНДАНГИЙН МАНАЛЖАВ.....	16
1.13. ЛУВСАНДАМБЫН ДАШНЯМ.....	16
1.14. ЛУВСАНДОРЖИЙН БОЛД.....	17
1.15. ЛУВСАНЖАВЫН ЧУЛУУНБААТАР.....	18
1.16. ЛУВСАНЫ ХАЙСАНДАЙ.....	18
1.17. НООСГОЙН АЛТАНЦЭЦЭГ.....	19
1.18. ОЙДОВЫН НЯМДАВАА.....	19
1.19. РИНЧИНСАМБУУГИЙН ОТГОНБААТАР.....	20
1.20. САМБУУГИЙН ХӨВСГӨЛ.....	21
1.21. СОДНОМЫН ЦОЛМОН.....	21

1.22. ТӨЙТОГИЙН ТӨМӨРХҮЛЭГ.....	22
1.23. ТҮВДИЙН ДОРЖ.....	22
1.24. ЦОГТ-ОЧИРЫН ИШДОРЖ.....	23
1.25. ЦЭДЭВИЙН ӨНӨРБАЯН.....	23
1.26. ЧОЙСҮРЭНГИЙН ДАГВАДОРЖ.....	24
1.27. ЭНХБАЯРЫН РАВДАН.....	24
1.28. ЭРДЭНИЙН ПҮРЭВЖАВ.....	25
1.29. АНДРАШ УЛС)	26
РОНА-ТАШ (УНГАР	
1.30. ГРАЙВОРОНСКИЙ ХОЛБООНЫ	27
ВЛАДИМИР ВИКТОРОВИЧ (ОРОСЫН УЛС)	
ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛАЛЫН ОЛОН УЛСЫН ХОЛБОО БОЛОН МОНГОЛ СУДЛААЧИДТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГҮҮД, ЗАХИДЛЫН ЭМХЭТГЭЛ.....	28-33

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛАЛЫН ХУРЛУУД

3.1. “ЗАЛУУ МОНГОЛ СУДЛААЧДЫН МОНГОЛ СУДЛАЛ БА ӨНӨӨ ҮЕ” ЭРДЭМ ХУРАЛ.....	34
3.2. “МОНГОЛ СУДЛАЛ БА МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО: СУДАЛГААНЫ БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА” ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТДИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ.....	

3.3. “МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ.....	36
ДҮГНЭЛТ.....	38
ХАВСРАЛТ 1	39-53
ХАВСРАЛТ 2	54-65

УДИРТГАЛ

Монгол төрийн бодлогын цөмд монгол судлал чухал байр суурь эзэлдэг. Монгол судлалын ай савд хамаарах шинжлэх ухааны салбар чиглэлийг өргөжүүлэх, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг тэлэхэд бид анхаарах хэрэгтэй. Монгол судлалын хүрээнд хэл, түүх, соёлын уламжлалт салбараас гадна археологи, антропологи, нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн орчин үеийн чиг хандлагыг хамруулж, илүү том зургаар харах нь чухал байна. Ялангуяа Монголч судлаачдын аман болон бичгийн түүхийн сан хөмрөг монгол судлалд өнөөг хүртэл бий болоогүй байна. Монгол судлалыг одоогийн түвшинд бий болгосон нэр хүндтэй эрдэмтдийн аман түүх, монгол судлалын талаар хийж гүйцэтгэсэн ажил, бусад монгол судлаачдын талаарх асуудлыг хамруулсан бүрэн хэмжээний видео ярилцлага бүхий сан хөмрөг урд өмнө манай улсад хийгдэж байсангүй.

Олон улсын монголч эрдэмтдийн V их хурал 1987 оны 9 дүгээр сарын 14-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хуралдаж гучин зургаан орны 300 орчим эрдэмтэд оролцсон байна. Тус хурлын үеэр Олон улсын монголч эрдэмтдийн их хурлын Байнгын Хороог өргөтгөн “Олон Улсын Монгол Судлалын Холбоо”-г байгуулж, тогтмол үйл ажиллагаатай төрийн бус байгууллагыг байгуулсан билээ. Энэ үеэс эхлэн Олон Улсын Монгол Судлалын Холбоонд дэлхий дахинд нэртэй олон монгол судлаач эрдэмтдийн захидал бичиг, тэдэнд тус холбооноос бичсэн захидал, дэлхийн олон оронд буй монгол судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвүүдээс тус холбоонд илгээсэн захидал, албан хүсэлт зэрэг хувь хүн, байгууллагуудаас ирсэн, явуулсан захидал, бичгүүд хуримтлагдан хадгалагдаж байна. Захидал, бичиг нь түүхийн судалгааны эх сурвалжийн нэг төрөл бөгөөд ялангуяа хувь хүн, намтар судлалын үндсэн хэрэглэгдэхүүн болдог

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

билээ. Үүнээс гадна алба захидал бичсэн хувь хүний мэдлэг, судалгааны цар хүрээг илтгэн харуулж чадах нэг үзүүлэлт юм. Эдгээрийг эмхэтгэн гаргаж, судалгааны эргэлтэд шаардлага бий болсон юм.

Мөн Монгол судлалын хурлыг тогтмолжуулж, тухайн салбарын залуу эрдэмтдийг дэмжих, хамтран бүтээл гаргах боломжоор хангах нь чухал юм.

Эдгээрийн хүрээнд монгол судлалын өнөөгийн байдал болон цаашдын хандлагыг тодорхойлох нь зүйтэй билээ.

Судалгааны эх сурвалж, баримт, хэрэглэгдэхүүн:

Нийт А4 хэмжээний 330 хуудаст бүхий 274 захидал, бичгүүдийг цуглуулж, монгол бичгээр буй баримтуудыг кирил үсэгт буулган хөрвүүлж, орос, англи, монгол хэлээр буй баримтуудыг эмхэтгэв. 274 захидал, бичгүүдийг Гадаад Харилцааны Төв Архиваас 13 баримт, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс 53 баримт, Монгол Улсын Үндэсний төв архиваас 189, Олон Улсын Монгол судлалын холбооноос 119 баримтыг авчээ.

Монгол судлалын нэрт 30 эрдэмтдээс ярилцлага авч, сан хөмрөг үүсгэлээ. Захидал бичгийн агуулгын хувьд Монгол улсын шинжлэх ухааны байгууллага Судар бичгийн хүрээлэнгээс гадаадын олон монголч эрдэмтэдтэй харилцаж эхэлснээс эхлээд Шинжлэх ухааны хүрээлэнгээс ЗХУ-ын олон шинжлэх ухааны байгууллагууд тэр дундаа Зөвлөлтийн ШУА-ийн Дорнодахины хүрээлэн болон бусад их дээд сургууль, хүрээлэнгүүдтэй өргөнөөр харилцаж байсан баримтуудыг өргөн ашиглав.

Судлагдсан байдал:

Эдгээр баримт бичгүүд өмнө нь цогцоороо судалгааны эргэлтэд орж байгаагүй юм.

Судалгааны зорилго, зорилт:

- Монголч эрдэмтдийн бичгийн болон аман түүхийн сан хөмрөг бүрдүүлэх,
- Энэхүү эмхэтгэлд багтсан монголч эрдэмтдийн бичиг захидал нь Олон Улсын Монгол Судлалын Холбооны үйл ажиллагааг илтгэн харуулахаас гадна ХХ зууны 6 Монгол Улсын шинжлэх ухааны салбарын гадаад харилцаа, гадаадын монголч эрдэмтдийн Монгол улстай харилцаж байсныг тодруулах,

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

-Монгол судлалын үйл ажиллагаа, монгол судлалын тулгамдсан асуудлуудаар эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, -Монгол судлалын ирээдүйн чиг хандлага, одоогийн нөхцөл байдлыг дүгнэх юм.

Судалгааны арга зүй, арга:

Нийгмийн шинжлэх ухааны нийтлэг аргууд болох ярилцлагын, баримт бичгийн шинжилгээний аргыг судалгааны бүлэг зүйлийн онцлогт тохируулан хэрэглэсэн.

Сэдвийн он цагийн хязгаар:

Сэдвийн хамрах хүрээ, агуулга, холбогдох зүйлсийг судлах эх сурвалжийн байдал зэргийг харгалзан үзэж 1921 оноос 2000 он хүртэлх ная гаруй жилийн хугацаан дах монголч эрдэмтдийн захидал бичгийг хамруулан авч үзлээ.

Судалгааны шинэлэг байдал:

1. Монгол судлалын баримт бичгүүдийг дан ганц Олон Улсын Монгол судлалын холбоо бус бусад холбоотой байгууллагуудын баримтыг хамруулан цогцоор нь эмхэтгэхийг зорьсон,
2. Монголч эрдэмтдийн мэдээллийн тусгай сан хөмрөг бүрдүүлэхийг зорьсон,
3. Монгол судлалын ирээдүйн чиг хандлага, одоогийн нөхцөл байдал, тулгамдсан асуудалд хариу өгөхийг зорьсон.

Онол-практикийн ач холбогдол:

Монгол судлалыг хөгжүүлэхэд, өнгөрсөн болон одоог холбон судалж ирээдүйн судалгааны чиг хандлагыг бий болгосноороо судлагдахууны чухал ач холбогдолтой. Онолын болон практик ач холбогдлын хувьд монгол судлалд урьд өмнө бичигдэж байгаагүй шинэ мэдээлэлээр хангах, онолын чиг баримжааг тодорхойлж өгөх, монгол судлалыг сонирхсон хэн бүхэнд танин мэдэхүйн ач холбогдолтой. Монголч эрдэмтдийн намтар, түүхийг өргөн хүрээтэй судалж, олон баримт эх хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэд оруулж ирснээр дагнан судалгаа хийх залуу судлаачдад арга зүйн чиг баримжааг өгнө.

Мөн монгол судлалын талаар цогц бүтээл туурвих, сурах бичиг зохиох, гадаад бодлогыг тодорхойлоход уг судалгааны үр дүнг ашиглах бүрэн боломжтой.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛААЧИДЫН МЭДЭЭЛЛИЙН САН ХӨМРӨГ, СУДАЛГААНЫ БААЗ

1.1. АМАРМЭНДИЙН ПУНСАГ

Амармэндийн Пунсаг бол Монгол улсын Шинжлэх ухааны академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Монголын эзэнт гүрэн ба дундад үеийн түүхийн судалгааны салбарын тэргүүлэх ажилтан бөгөөд Монголын Юань улс, Монголын Нууц товчоо, монголын уламжлалт ёс



заншил зэрэг сэдвээр судлагаа хийдэг түүхч, эрдэмтэн юм. Тэрээр 1983-1992 онуудад ӨМӨЗО-ны Багшийн их сургуульд багшилж байсан. 1992 оноос Монгол улсын ШУА-ийн дэргэдэх аспирантурт суралцаж “Монголын уламжилт цээрийн ёс” сэдвээр 1996 онд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан. Одоо ШУА-ийн Түүхийн хүрээлэнд Дундад зууны үеийн Монголын түүхийн салбарын эрхлэгчээр ажиллаж байна. Тэрээр 'Монгол шатар ба монгол соёл' (1993), 'Монголчуудын уламжлалт цээрийн ёс' (2003), 'Монголын Нууц Товчооны судалгаа' (2008), 'Монголын Нууц Товчоо дахь ёс заншилын судалгаа' (2010), 'Тэнгэрийн их Юань улсын түүхэн тэмдэглэл' (2010) ганц сэдэвт зохиол болон 'Монголын их Юань улс' (2010) зэрэг арав гаруй хамтын бүтээл, 60 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж Герман, Орос, Япон, Хятад, Солонгос зэрэг оронд зохиол нь нийтлэгдсэн байна.

1.2. ГААДАМБЫН БИЛГҮҮДЭЙ



Г.Билгүүдэй нь 1989 оноос хойш ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажлыг «Монголын нууц товчоон»-ы судлал, Монголын эртний уран зохиолыг судалсан Ц.Дамдинсүрэн, Ш.Гаадамба нарын намтар, эрдмийн ажлын судлал, Утга зохиолын онол, уран сайхны шүүмжлэлийн түүх гэсэн үндсэн гурван чиглэлээр хийж ирсэн. Г.Билгүүдэй нь

Хэл зохиолын хүрээлэнд орсон цагаасаа «Монголын нууц товчоон»-ы судлалаар «Цагаан шонхорын тухайд» (1991), «Барилдуга гэдэг үгийн тухай» (1994), «Өгэдэй Толуй хоёрын дүрийг эргэцүүлэн бодохуйд» (1995), «Монголын баатарлагийн туулийн гол баатрын намтарчлалыг “Монголын нууц товчооноос” хайхад» (1998), «Монголын нууц товчооны уран сайхны асуудалд» /1999/ зэрэг судалгааны өгүүллийг бичиж 1999 онд «Аман уламжлал ба “Монголын нууц товчоо”» сэдэвт диссертац бичиж Хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2020 онд “Монголын нууц товчоон”-ы авантекст үзэгдлийн судалгаа” суурь судалгааны хүрээнд «Монголчуудын аман уламжлал ба «Монголын нууц товчоон» номыг хэвлүүлэв. Г.Билгүүдэй нь 1996 оноос Хэл зохиолын хүрээлэнгийн Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн эрхлэгчээр ажиллаж 1998 онд «Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол номын бүртгэл» хэмээх каталогийг анх удаа хийж хэвлүүлэв. Г.Билгүүдэй нь өөрийн аав Шанжмятавын Гаадамбын намтар, уран бүтээл, эрдэм судлалын ажлыг судлах, эрдэм бүтээлийг нь хэвлүүлэн дэлгэрүүлсэн. 2007 онд уран сайхны шүүмжлэлийн түүхийн хичээлд зориулан «Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм» гэсэн сурах бичгийг хэвлүүлэв. Уран зохиолын онолын судалгааны хүрээнд манай улсад Өрнө болон Дорнын уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний талаар бие даасан бүтээл хараахан гараагүй байсан орон зайг нөхөн гарсан энэхүү ном эрдэмтэн, судлаачдын зүгээс өндөр үнэлэгдэж байна. Монголын эртний уран зохиолын алдарт дурсгал “Монголын нууц товчоон” судлалаар мэргэшин судалгааны 17 ном, эрдэм шинжилгээний 38, эрдэм шинжилгээ сурталчилгааны 52 өгүүлэл бичиж хэвлүүлсэн.

1.3. ГАЛИНДЭВИЙН МЯГМАРСАМБУУ



Тахилт овгийн Галиндэвийн Мягмарсамбуу нь Архангай аймгийн Тариат сумын Цагаан нуур бригадын Сөртөд төржээ. 1982 онд нийслэлийн 10 жилийн 53-р дунд сургууль, 1986 онд Цэргийн Нэгдсэн Дээд Сургуулийн улс төрийн анги, 2002 онд Хятадын Ардын

Чөлөөлөх Армийн Гадаад Хэлний Дээд Сургуулийн хятад хэлний курс төгссөн байна. Улс төрийн ажилтан, түүхч мэргэжилтэй. Доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа. Тэрбээр 1986 оноос Монголын Ардын Армийн 197, 186 дугаар ангид салбарын захирагчийн улс

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

төрийн орлогч, 1993 оноос Цэргийн Эрдэм Шинжилгээний Хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 2000 оноос Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, 2012 оноос тус хүрээлэнгийн дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллажээ. Одоо ШУА-ийн Түүх, Археологийн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж байна. 2014 онд Япон улсын “Showa” их сургуульд зочин судлаачаар ажиллаж байсан. Доктор (Ph.D), профессор, Г.Мягмарсамбуу нь монгол цэргийн түүх, намтар судлал, угсаатны зүйн чиглэлээр судалгаа явуулж, судалгааны бие даасан бүтээл 20 гаруйг туурвиж, 10 гаруй бүтээлд хамтран зохиогчоор оролцон, судалгааны болон сурталчилгааны 60 гаруй өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгосноос гадна 8 бүтээл эмхтгэн хэвлүүлж, бусад судлаачдын 9 бүтээлийг хянан зөвлөсөн байна. Доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу 2011-2012 онд “Монгол улсын цэрэг, цэргийн жанжид” (XX зууны эхэн) хэмээх 3 боть бүтээл бичиж хэвлүүлсэн бөгөөд эдгээрт монгол цэргийн домогт жанжин Ардын Хатан баатар Магсаржав, Ялгуун баатар Сумъяа, Манлай баатар Дамдинсүрэн нар болон тэдний хамтран зүтгэгчид, цэрэг эрсийнх нь амьдрал тэмцэл, түүхэнд гүйцэтгэсэн үүргийг архивын баримтанд тулгуурлан олон талаас нь харуулж, үнэлж дүгнэсэн байна.

1.4. ДАЛАНТАЙН ЦЭРЭНСОДНОМ

Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Д.Цэрэнсодном 1962 оноос Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний дэд, ахлах, тэргүүлэх ажилтнаар нийтдээ 55 тасралтгүй ажиллаж байна. Дэлхийн



түмний уран зохиолын алтан сан хөмрөгт аль хэдийнээ хүндтэй байр сууриа эзэлсэн “Монголын нууц товчоон”-ы судалгаа, орчуулга, тайлбарыг манай эрдэмтэд эртнээс сонирхон оролдсон билээ. XX зууны эхэн үеийн Баргын Цэнд гүнтний 1917 оны хамгийн анхны монгол орчуулга сийрүүлэг, академич Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн монгол хэлнээ бүрэн төгс яруу сайхан буулгаж 1947 онд хэвлүүлэн Монгол улсын Төрийн шагнал хүртсэн анхны уран сайхны иж орчуулга гарчээ. Академич Д.Цэрэнсодном Монгол улсын

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “Монголын нууц товчоон” судлалын төвийг 2004 онд үүсгэн байгуулсны зэрэгцээ Монгол улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн зарлигаар Монгол улсын Төрийн хүндэтгэлийн өргөөнд залах Монголын бичмэл түүхэн сурвалжийн хамгийн анхны дээж бичиг болох “Монголын нууц товчоон”-ы сонгомол эхийг сэргээн боловсруулах ажлын хэсгийг удирдан ажиллаж, сонгомол эхийг нийтлүүлж, айл бүрийн өргөө гэрийн хойморт залсан билээ. Академич Д.Цэрэнсодномын олон жилийн эрдэм шинжилгээний үйл хэрэг, ажил хөдөлмөр, бүтээл туурвилыг нь Монгол улсын төр засгаас өндрөөр үнэлж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон (1997), Монгол улсын Төрийн шагнал (1998), “Шинжлэх ухааны тэргүүний Академич Д.Төмөртоогоо, гавж Ш.Сонинбаяр, академич Д.Цэрэнсодном, профессор Ч.Хишигтогтох нар Шинжлэх Ухааны Академийн Мэдээ 2017 оны №02 (222) - 80 - ажилтан” (1999) цол, Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн (2007) цол хүртээжээ. Мөн 2015 онд Олон улсын алтай судлалын байнгын бага хурал (PIAC) [Permanent International Altaistic Conference]-ийн Алтан медаль хүртжээ.

1.5. ДАМДИНСҮРЭНГИЙН ЦЭВЭЭНДОРЖ

Д. Цэвээндорж нь 1966 онд Өвөрхангай аймгийн Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийг "Алтан медаль" тай төгсөж ШУА-ийн захиалгаар Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуульд элсэн суралцаж "археологич" мэргэжлээр



төгссөн, 1983 онд "Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал" сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг, 1998 онд "Монголын эртний урлагийн түүх" сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ. Тэрээр хээрийн шинжилгээг 80 гаруй удаа удирдан зохион байгуулж Монгол орны 21 аймаг, ихэнхи сумдын нутгийг хамарсан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Түүний олон жилийн судалгаа шинжилгээний ажлын үр дүн, эрдмийн хамтрагчдын хүчин чармайлтаар Увс нуурын ай сав газар, Орхоны хөндий, Монгол Алтайн хадны зураг, Бурхан Халдун ба түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн болно. Д. Цэвээндорж нь эрдэм судлалын ажлынхаа зэрэгцээ 1972 оноос эхлэн МУИС, МУБИС, Улаанбаатарын их

ДОТООД АЗИЙН БУС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

сургуулиудад багшлан, Монголын археологичдын хэдэн үеийг сурган хүмүүжуулэгч, ачлалт багш юм. Түүний удирдлагаар доктор, магистрын зэрэг хамгаалсан олон шавь нар нь гадаад, дотоодод археологийн шинжлэх ухааны судалгаа, сургалтын байгууллагуудад амжилттай ажиллаж байна.. Академич Д. Цэвээндорж нь Монголын археологийн шинжлэх ухааныг шинэ түвшинд хөгжүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх судлаачдын залуу халааг бэлтгэх, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагыг удирдан зохион байгуулахад өөрийн бие сэтгэлээ зориулсан манай улсад төдийгүй бус нутаг, олон улсын хэмжээнд нард гарсан эрдэмтэн.

1.6. ДИЙМААЖАВЫН ЭРДЭНЭБААТАР

Археологич, түүхч, хүрэл зэвсэг, хүннү судлаач Түүхийн ухааны дэд доктор, профессор. Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхэмийн эрхлэгч. Монголын эртний хүрэл зэвсгийн үе ба Хүннүгийн археологийн судлаач. Хөдөлмөрийн хүндэт медаль, ШУ-ны



тэргүүний ажилтан цол, тэмдэг, Боловсролын тэргүүний ажилтан цол, тэмдэг, Жак Уэтерфордын нэрэмжит дэд байрын шагналт; Тэрээр газрын хөрсөн дээр ба доор үлдсэн Монголчуудынхаа агуу их түүх, соёлыг хэн ч маргахын аргагүйгээр “Бидний өв соёл энэ шүү” гэж дэлхийд харуулахын тулд ерээд оноос хойш Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Эгийн голын нутагт Хүннүгийн булшийг малтах ажлаа эхэлж хүннүгийн үеийн бэхийн чулуун янтай, хүрэл дуулга, хүрэл морь зэрэг дэлхийд нэн ховор олдворуудыг олж илрүүлсэн. Цаашид Хүннүгийн бичиг үсэг, ном судрыг олох чин зорилготой ажилладаг. Мөн “Монгол нутаг дахь дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл”, “Монгол Алтайн хүн чулуун хөшөө”, “Эртний металлург боловсруулалтын түүх”, Монголын түүхийн I ботийг бүтээхэд хүрлийн үеийн тухай гэх мэт нэгэн сэдэвт бүтээл 5, Хамтын бүтээл 8, Эрдэм шинжилгээний өгүүлэл 160- ийг туурвин бүтээгээд байна. Түүний ахласан археологийн баг Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн нутаг Балгасын тал хэмээх газар орших Гол мод нэртэй Хүннүгийн хаадын булш бүхий газрыг шинээр илрүүлэн олж, Хүннүгийн хааны булш олсноо зарласан. Архангай аймгийн Хайрхан сумын Хүнүй голын хөндийд Гол модны Хүннүгийн хаадын булштай газартай ижил нэртэй, дурсгалын хувьд ч

ижил байгааг анзаарч түүхэн дурсгалтай ижил газраас ялгахын тулд “Гол мод-2” хэмээн нэрлэжээ. Археологийн судалгааны үр дүн Монгол орны хүрэл зэвсгийн үеийн түүхийн он цагийг, өмнөх судалгааны үр дүнгээс 1000- 1500 жилээр урагшлуулан “Чемурचेкийн соёл”, Мөнххайрханы соёл”, “Тэвшийн соёл” зэрэг монгол нутагт хүрэл зэвсгийн эрт болон дунд үед амьдарч байсан овог аймгуудын үлдээсэн дурсгалуудыг шинээр илрүүлэн олсон. Хүннүгийн их хааны булшны малтлага судалгааны үр дүн бол түүхэндээ анх удаа монголчууд гадны тусламжгүйгээр бие даан бүрэн цогцолбороор дагуул булш болон тахилын байгууламжийн хамт малтан шинжилсэн. Хүннүгийн их хааны булш хэмжээний хувьд ч тэр, малтлага судалгааны ажлын үргэлжилсэн цаг хугацаа, оруулсан хөрөнгө оруулалт, ажилласан хүний тоо, илрэн олдсон археологийн эд өлгийн дурсгал зэргээрээ олон дээд амжилтыг тогтоосон.

1.7. ДОЖООГИЙН ЦЭДЭВ

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, төр нийгмийн зүтгэлтэн, зохиолч, орчуулагч, судлаач, багш сурган хүмүүжүүлэгч, шинжлэх ухааны доктор, профессор Д.Цэдэв нь 1956-1958 онд Улаанбаатар хотын Багш нарыг бэлтгэх сургууль, 1958-1963 онд Монгол Улсын их



сургуулийн Монгол хэл, уран зохиолын ангийг тус тус дүүргэж, улмаар 1971 онд дэд эрдэмтэн, 1997 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ. Тэрбээр 1963-1973 онд Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар, Хэл зохиолын хүрээлэнд судлаач, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1973-1977 онд Улаанбаатар хотын Соёл урлагийн байгууллагын намын хорооны дарга, 1977-1990 онд Монголын зохиолчдын эвлэлийн хорооны дарга, 1990-1992 онд Соёл урлаг судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1992-1996 онд Япон Улсын Токиогийн Гадаад судлалын их сургуульд зочин профессор, 1996-1998 онд Соёл урлаг судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-д багш, 1998-2010 онд Соёл урлагийн их сургуулийн захирал, Соёл урлагийн хүрээлэнгийн захирал, 2010 оноос Улаанбаатарын их сургуульд зөвлөх профессороор ажиллаж байв. Д.Цэдэвийн “Монголын яруу найргийн уламжлал шинэчлэл”, “Зохиолчийн урлах эрдэм”, “Монголын нууц товчоо”-ны бэлгэдэл зүй”, “Хүүхэн хутагтын дууны

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

судлал”, “Миний туурвил”, “Монголын соёлын түүх”, “Монголын шинэ утга зохиолын түүх”, “Зохист аялгууны судалгаа” зэрэг судлал шүүмжлэлийн зохиолууд, Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, С.Буяннэмэх, Б.Содном нарын зэрэг ахмад үеийнхний бүтээл туурвилын өв санг судлан шинжилсэн бүтээлүүд, гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хурлуудад тавьсан илтгэлүүд нь дэлхийн монгол судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Түүний 1959 онд хэвлүүлсэн “Алт мөнгө-чулуу, Арвай буудай амьдрал” хэмээх орчуулгын зохиол нь олон арван орчуулгын бүтээлийнх нь эхлэл байсан төдийгүй, судалгааны арвин их хэрэглэгдэхүүний үүд болжээ. Тэрбээр ОХУ-ын Дорнод Сибирийн Соёл урлагийн академийн хүндэт профессор, БНХАУ-ын Өвөр Монголын Багшийн их сургууль, Бээжингийн Төвийн үндэстний их сургуулийн хүндэт профессор цол тус тус хүртэж, Монгол Улсын соёл урлаг, утга зохиолоор докторын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн дарга, гишүүний үүргийг нэр төртэй гүйцэтгэж ирсэн эрхэм хүндтэй эрдэмтэн байв. Монголчуудын түүх, утга соёлын үнэт өвүүдийг судлан шинжилсэн, уран сайхнаар туурвисан түүний бүтээлүүд орос, англи, испани, франц, япон, герман, араб, мажар, болгар, вьетнам, казах, киргиз зэрэг 30 гаруй орны хэлээр хэвлэгдэн монголын утга соёл, урлагийг дэлхийд танин мэдүүлэх, түгээн дэлгэрүүлэх их үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан билээ.

1.8. ДОМИЙН ТӨМӨРТӨГӨӨ

1962 онд МУИС-ийг төгсөхдөө Лу багшийн удирдлага дор «Бодизарьяа аватарын тайлбар» сэдвээр дипломын ажил бичиж хамгаалснаас хойш өнөөдрийг хүртэл 40 гаруй жил монгол хэл шинжлэлийн судалгаа, шинжилгээний ажил хийж байна. Монгол хэлний түүхэн



хэлзүй судлал бол судалгааны ажлын гол цөм. Үүнд монгол хэлний эртний бичгийн дурсгал, монгол хэлний хувьсч, хөгжиж ирсэн түүх зэргийг хамруулан авч үзэх юм. Тухайлбал, Монгол хэлний эртний дурсгал нь уйгаржин, дөрвөлжин, араб, хятад үсгээр тэмдэглэсэн байдаг. Тэдгээр нь хэдийгээр үсэг бичиг нь өөр боловч монгол хэлний үгийг тэмдэглэсэн дурсгалууд юм. Түүнийг бүтээсэн цаг үе нь 13-16 дугаар зууны үед хамаарна. Тусч байгаа хэлний онцлог нь найм, есдүгээр зууны үеэс эхлэн 14, 15 дугаар зууны

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

хүртэлх хугацааг хамарсан байдаг. Одоогоос 1000 шахам жилийн өмнө монголчууд өөрийнхөө хэлний бүхий л бүтэц тогтолцоонд тохирсон бичиг үсгийг боловсруулсан байдаг.ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Д.Төмөртогтоо нь МУБИС-ийн дэд захирал, МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн дарга, ШУА-ийн Хэл-зохиолын хүрээлэнгийн захирал, Токиогийн Гадаад судлалын их сургуулийн Ази, Африкийн хэл, соёл судлалын хүрээлэнгийн зочин профессор, Олон Улсын Монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан бөгөөд одоо Олон улсын Монгол судлалын холбооны Хүндэт ерөнхийлөгч, зөвлөхөөр ажиллаж байна. Тэрбээр 1962 онд МУИС-ийг монгол хэл, уран зохиолын багш мэргэжлээр төгссөнөөс хойш сургалт, судалгааны байгууллагад сурган хүмүүжүүлэх, судлан туурвих, удирдан зохион байгуулах ажлыг тасралтгүй 50 гаруй жил үр дүнтэй хийжээ.

1.9. ДОРЖПАЛАМЫН СУМЪЯА

1987 оноос Хэл зохиолын хүрээлэнд ажиллаж байна. Эхний хэдэн жил “Нэвтэрхий толийн тасаг”-т, дараа нь Түвд судлалын тасагт ажиллаж байна. Анх утга зохиолын ертөнцөд Б.Явуухулан гуай намайг хөтөлж оруулсан. ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнд Чой.Лувсанжав



багш оруулж эрдэм шинжилгээний ажилтан болгосон. Дараа нь Л.Хүрэлбаатар багшийнхаа удирдлагад ажилласан. Багш нараа дурдахын учир нь би нэг талаар их азтай, нөгөө талаас энд насаараа зүтгэх өртэй. Багш нар маань “Энэ юм хийх байх” гэсэн итгэлийг надад хандуулсан учраас, би тэр алдартай эрдэмтдийн итгэлийг хүлээсэн учир бүтээл хийх ёстой гэж ажилласаар ирсэн. Хэл зохиолын хүрээлэн, монгол хэлний буянаар судалгааны ажлууд хийхээс гадна Оросын их сургууль, Хятадын их сургуульд тодорхой хугацаанд урилгаар багшилж байсан.

1.10. ЖИГЖИДИЙН БОЛДБААТАР

Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, академич Ж.Болдбаатар нь МУИС-ийн түүхийн салбар, Москвагийн Нийгмийн Ухааны Академийг олон улсын харилцааны чиглэлээр төгссөн. 1979 онд академид түүхийн ухааны дэд эрдэмтэн 1991 онд түүхийн

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

ухааны докторын зэрэг хамгаалсан. 1991-2012 он хүртэл МАХН-ын дэд дарга, УИХ-ын гишүүн, УИХ дахь МАХН-ын бүлгийн дарга, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр тус тус сонгогдож, томилогдон ажиллаж, төрийн дээд байгууллагад 20 шахам жил алба хааж байсан. МУИС, Намын дээд сургууль, Шихихутуг их сургууль, ОУУБИС, ШУТИС-д 47 жил багшилж, хичээл зааж ирсэн. Монголын орчин үеийн түүх, Монгол улсын төр эрхзүйн түүх, улс төрийн түүх, түүхэн хүн судлалын чиглэлээр голчлон ажиллаж, ном, товхимол 70 шахмыг, хамтын бүтээл 50 гаруйд оролцож, судалгааны өгүүлэл 180, сурталчилгааны өгүүлэл 110-ыг тэрлэн, шавь нар, хамтран зүтгэгчдийнхээ 131 номыг хянан нягталж, өмнөх үг бичжээ. Тэр бээр уран сайхны хоёр, баримтат киноны 40 шахам зохиол, сценари бичиж, дэлгэцнээ гаргасан байна. Бүтээлүүд нь Орос, Англи, Герман, Хятад, Япон, Солонгос, Унгар, Чех зэрэг хэлээр хэвлэгджээ.

1.11. ЖУРЫН БАЯНСАН

Ж.Баянсан нь МУИС-ийг Монгол хэл уран зохиолын багш мэргэжлээр, Москвагийн Их Сургуулийн аспирантурыг төгссөн. 1975-1980 онд МУИС-ийн Хэлбичгийн Факультетэд багш, 1981-1983 онд Японы Осакагийн Гадаад Судлалын Их Сургуульд багш, 1983 оноос одоо



хүртэл МУИС-ийн Монгол Судлалын Сургуульд багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. 2007 онд БНХАУ-ын Төвийн Үндэстний Дээд Сургуульд зочин профессор. Монгол хэлний задлаг, нийлэг хам бүтцийн харьцаа, хамаарал, хэлний соёл судлал, хэлц нэгжийн асуудал, сэтгэц болон угсаа хэлшинжлэлээр судалгаа хийдэг. Ардын боловсролын тэргүүний ажилтан 1991 онд, Монгол Улсын Гавьяат багш цол 2010 онд хүртсэн. “Психолингвистическое особенности восприятия учебного текста студентами – филологами” сэдвээр хэлбичгийн ухааны докторын зэрэг 1991 онд хамгаалсан. “Монгол хэлний зөв бичих дүрмийн гарын авлага”, “Хэл шинжлэлийн дасгалын хураамж”, “Орчин

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

цагийн монгол хэлний өгүүлбэрзүй”, “Монголоор ярих тохиолдлууд, монгол ёс заншил”, “Монголчууд, монгол ёс заншил”, “Хэлшинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь”, “Монгол хэл, уран зохиолын лавлах”, “Орчин цагийн монгол хэлний зүй”, “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ”, “Монгол хэл 10-р анги”, “Сурагчийн гарын авлага” зэрэг ном, сурах бичиг, гарын авлага дангаар болон хамтаар бичиж хэвлүүлсэн.

1.12. ЛУВСАНВАНДАНГИЙН МАНАЛЖАВ

Судлаач Л.Маналжав Монгол Улсын гавьяат багш болжээ. Тэрбээр, Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд "Монголын нууц товчооны хэлний авиалбарын тогтолцоо" сэдвээр 1973 онд Хэл шинжлэлийн ухааны дэд эрдэмтний зэргийг хамгаалжээ. "Монголын



нууц товчоо" судлалаар хэл шинжлэлийн ухааны эрдмийн зэрэг хамгаалсан хамгийн анхны эмэгтэй доктор болж, Монгол судлалын түүхэнд нэрээ мөнхөлсөн юм. Түүний эрдэм шинжилгээний удирдагчаар академич Бямбын Ринчен профессор ажилласны зэрэгцээ албан ёсны шүүмжлэгчээр нь академич Цэндийн Дамдинсүрэн, академич Амгаагийн Лувсандэндэв ажиллаж байжээ.

1.13. ЛУВСАНДАМБЫН ДАШНЯМ

Л.Дашням нь Москва хотноо Олон улсын харилцааны Дээд сургууль, ОХУ-ын ШУА-ийн Байгалийн шинжлэл, техникийн түүхийн Хүрээлэнгийн аспирантурыг дүүргэжээ. Олон улсын эдийн засагч, Шинжлэх ухаан судлаач, зохиолч, яруу найрагч, нийгмийн



зүтгэлтэн. Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ОХУ-ын Тува улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн. Шинжлэх ухааны болон Ардын боловсрол, Соёлын тэргүүний ажилтан, МЗЭ-ийн нэрэмжит шагналтан, Улаанбаатар хотын Хүндэт иргэн тэмдэгтэн. Монголын Хүмүүнлэгийн ухааны Академийн Ерөнхийлөгч, Монгол уламжлал Академийн Тэргүүн, ШУА-ийн Бага Чуулганы гишүүн, Философийн Хүрээлэнгийн Эрдмийн

Зөвлөлийн гишүүн, “Идэр” Их сургууль, “Энх Орчлон “Дээд сургуулиудын Эрдмийн Зөвлөлийн дарга, “Соёл Эрдэм” Дээд сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүн, “Чингис хаан” Хаадын Музейн Эрдмийн Зөвлөлийн гишүүн, ШУА-ийн Олон улсын харилцааны Хүрээлэнгийн Хүндэт профессор, ӨМӨЗО-ны Багшийн Их сургуулийн Зочин профессор, Олон улсын Тэнгэр судлалын Сангийн (Якут) дарга, “Алтайн улсын Соёлын Дээд сургууль”-ийн (ОХУ-ын Алтайн хязгаар) “Эрдэм шинжилгээний бичиг” сэтгүүлийн Редакцын Зөвлөлийн гишүүн, “Шинжлэх ухаан, амьдрал” сэтгүүлийн Хариуцлагатай нарийн бичгийн дарга. 1990 оноос улс төрийн амьдралд идэвхтэй оролцож, ардчиллыг хөгжүүлэх, улс төр эдийн засгийг хөгжлийн шинэ замналд дэвшүүлэх, нийгмийн өөрчлөлт, шинэтгэлийг бий болгох зорилтуудыг хэрэгжүүлэх онол, практикийн хамааралтай олон ажил үйлд хүчин зүтгэж байна. 1990-1992 онуудад АИХ-ын Орлогч дарга, 1992-1996 онуудад Улаанбаатар хотын ИТХ-ын Тэргүүлэгч гишүүнээр ажиллаж байсан бөгөөд 2001 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож байв. Бичиж туурвисан, эрхэлж нийтэлсэн болон орчуулгын 50 гаруй номтой.

1.14. ЛУВСАНДОРЖИЙН БОЛД



Академич Л.Болд 1971 онд Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар ажилд орсноос хойш тасралтгүй 50 жил ажиллаж байна. Тэрээр энэ хугацаанд олон арван бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж судалгаа

хийсний дотроос Орхон бичгийн дурсгал (I, II, III, IV, V, VI), БНМАУ-ын нутаг дахь хадны бичиг (1990), Монгол хэл шинжлэлийн түүхэн найруулал (2000), Монгол, Түрэг хэлний тооны нэр (2005), Хэлний засаглалын учир (2017), Үсэг бичиг үг хэллэгийн судалгаа (2017), Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь (2018), Монгол бичгийн хосгүй хоёр дурсгал (2021) зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. 2008 онд Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, 2018 онд Туркийн ШУА-ийн Нийгэм хүмүүнлэгийн салбарын дэлхийн шилдэг эрдэмтэн 2019 онд Туркийн ШУА-ийн Хүндэт гишүүн цолыг хүртжээ.

1.15. ЛУВСАНЖАВЫН ЧУЛУУНБААТАР



МУИС-ийн Монгол хэл уран зохиолын ангийг төгссөн. Доктор, МУИС-ийн дэд профессор. Монгол судлал, буддийн судлал, бөөгийн судлал сонирхдог. Англи-Монгол орчуулга, ерөнхий англи хэл, англи-америкийн түүх, орчуулгын онолын хичээл заадаг. “Монгол ярианы

хэл” 1,2, 1996, 1998, “Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл” 2002, “Төвдөөр гийсэн монгол мэргэд” 2004, “Шанзавын яам юу хийж байв” 2005, “Арьс шир боловсруулах тээрмийн монгол арга” 2005, “Бурхны шашинтнууд агуйд яагаад нямба хийдэг вэ” 2007, “Үндэсний монгол бичгийг сэргээн хэрэглэх хөдөлгөөний явц болон Чингис хаан монгол бичгийг төрийн бичиг болгосны 800 жилийн ой”, 2009 зэрэг нэг сэдэв бүтээл, “”Буддийн шашин соёлын тайлбар толь” Уб., 1999, 2000, “Төвд болон түүний хөрш орнууд” Лондон, 2003, “Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон”, 2001, “Орчин цагийн монгол хэлний сурах бичиг”, Англи, 2004 , зэрэг хамтын бүтээл туурвисан. Эрдэмшинжилгээний 30 шахам үгүүлэл бичиж, дотоодын болон олон улсын хуралд 30 шахам илтгэл хэлэлцүүлж, сурталчилгаа, шинжлэх ухааны хялбаршуулсан 20 гаруй өгүүлэл бичиж хэвлүүлжээ.

1.16. ЛУВСАНЫ ХАЙСАНДАЙ

1965 онд Москва хотноо Гадаад хартлцааны дээд сургууль дүүргэсэн.Олон улсын харилцааны түүхч мэргэжилтэй. 1980 онд “Монгол ба хөгжиж байгаа орнуудын харилцаа” сэдвээр түүхийн шинжлэх ухааны дэд доктор, 1999 онд “Монгол Улсын



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

үндэсний эрх ашиг ба гадаад бодлого:онол, практикийн асуудал” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.1974 оноос ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд ажиллаж байна.Л.Хайсандаа нь үндсэн ажлынхаа зэрэгцээгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Гадаад бодлогын зөвлөлийн гишүүн, МУ-ын Үндэсний Аюулгүйн зөвлөлийн шинжээчээр ажилладаг. Эрдэм шинжилгээний бие даасан ба хамтарсан нийт 14 ном зохиол, эрдэм шинжилгээний 120 гаруй өгүүлэл, илтгэл бичиж нийтлүүлсэн.

1.17. НООСГОЙН АЛТАНЦЭЦЭГ

Ноосгойн Алтанцэцэг нь 1977 онд ОХУ-н Санкт-Петербургийн Улсын Их сургууль, 1977 ОХУ-н Санкт-Петербургийн Улсын Их сургуульд Дорно дахин судлалд Хятадын түүхээр төгссөн. Тэрээр 1986 онд ОХУ-н ШУА-н Алс дорнодын хүрээлэнд Түүхийн ухааны



докторын зэрэг хамгаалсан. Судалгааны чиглэл нь Монгол улсын гадаад бодлого, Монгол-Хятадын харилцаа, Гадаад дахь монгол судлал, Олон улсын харилцаа юм. Түүний сүүлийн үеийн судалгаа нь оросын монгол судлалын анхны байгууллагууд, судалгааны томоохон бүтээлүүд, монгол судлалын өнөөгийн байдал, америкийн монгол судлалын эхлэл, судалгааны төвүүд, тэдний бүтээлүүд, БНХАУ байгуулагдсаны эхэн үед монгол судлалд гарсан өөрчлөлт, Бээжингийн их сургууль, өвөр монголын их сургуулийн монгол судлалын сургууль гэх мэт өргөн хүрээг хамарч байна.

1.18. ОЙДОВЫН НЯМДАВАА

Ойдовын Нямдаваа Ховд аймгийн Мөст суманд 1949 онд төрсөн, Улаанбаатар хотын 21 дунд сургуулийг 1967 онд, Москва хотын Олон Улсын Харилцааны Дээд сургуулийг 1972 онд төгсчээ. Мөн Москва хотын Дипломатын Академийг 1986 онд, Энэтхэгийн Дели хотын Хинди хэлний Дээд сургуулийг 1976 онд дүүргэжээ. 2002 онд профессор К.Варикогийн удирдлагаар Жавахарлал Неругийн Их сургуульд “Монгол-Энэтхэгийн харилцаа”



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

сэдвээр докторын зэрэг хамгаалсан. БНЭУ дахь Монгол Улсын элчин сайдын яаманд атташе, нарийн бичгийн дарга, зөвлөх болон Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, Афганистан улсад тусгай элч төлөөлөгч, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын Төрийн Ёслолын албаны дарга, УИХ –ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн зөвлөх, ГХЯ-д нарийн бичгийн дарга, зөвлөхөөр ажилласан. Сүүлийн жилүүдэд Дэлхийн Монголчуудын түүх, Монголын эзэнт улсын бүрэлдэхүүнд байсан Цагаадайн улс, Алтан Орд улс, Ил хант улсын түүх, соёлын өвийг голлон судалж ном бүтээл, баримтат кино бичиж, гэрэл зургийн үзэсгэлэн толилуулаад байна. Ном бүтээл, баримтат кино, үзэсгэлэнд Чингис хааны хүн төрөлхтөний түүхэнд оруулсан хувь нэмэр, Чингис хааныг дэлхийн улс орны төрийн тэргүүнүүд, судлаачид хэрхэн үнэлсэн үнэлэмж, Төв Азид Цагаадай хааны оруулсан хувь нэмэр, Алтан орд улсад Жүч, Бат хааны гүйцэтгэсэн үүрэг, бүтээсэн зүйл, Ил хант улсад Хүлэг хааны удмын хаадын оруулсан хувь нэмэр, уран барилга, улс төрийн тогтолцооны талаар бичиж нийтийн хүртээл болгожээ. Түүний нийтэд толилуулсан үзэсгэлэнгээс монголын ард түмэн, залуу үе дэлхийд тархсан монголчуудын түүх, монгол гаралтны тархац, түүх, соёлын өвийг танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтой болжээ. Ойдовын Нямдаваа ихэнх бүтээлээ англи хэлээр бичиж хэвлүүлсэн нь дэлхий нийт монголчуудын байр суурь, үзэл бодлыг ойлгоход тустай болсон байна. Одоо Ойдовын Нямдаваа Дэлхийн Монгол гарал үүсэлтний төв, Энэтхэг судлалын төвийн тэргүүнээр ажиллаж дэлхийн монголчууд, монгол гаралтай хүмүүсийн талаар судалгаа голлон хийж байна.

1.19. РИНЧИНСАМБУУГИЙН ОТГОНБААТАР

Р.Отгонбаатар нь МУИС-ийг Монгол хэл уран зохиолын багш мэргэжлээр төгссөн. Их сургуулиа төгсөөд сургуульдаа багшаар үлдэж, 1970-аад оноос хойш нэлээн хэдэн жил Монгол бичгийн хичээл зааж байсан. 1980-н оноос эхлэн Хэл зохиолын хүрээлэнд Төвд судлалын албанд академич Ц.Дамдинсүрэн багшийн удирдлагад ажилд орсноор өдийг хүртэл уг албанд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байна.



1.20. САМБУУГИЙН ХӨВСГӨЛ

Хэл бичгийн ухааны доктор (Sc.D), профессор С.Хөвсгөл нь 1982 онд Эрхүүгийн Их Сургуулийг төгссөн. 1992 онд "Монголын жүжгийн зохиолын төрөл зүйл бүрэлдсэн нь" сэдвээр хэлбичгийн ухааны дэд докторын зэрэг, 2005 онд "Саран хөхөөний намтар" жүжгийн



зохиолын шинжлэл" сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан. 1995 он "Монголын жүжгийн зохиолын төрөл зүйлийн асуудлууд" ном 1998 он "Орчин үеийн Монголын уран зохиолын түүх" III дэвтэрт "Жүжгийн зохиол" бүлэг 2014 он "Орчин үеийн Монголын уран зохиолын түүх" IV дэвтэрт "Жүжгийн зохиол" бүлэг 2004 он "Д. Равжаагийн "Саран хөхөөний намтар" жүжгийн "Горим"-ын эх бичгийн судалгаа" ном 2011 онд Д. Равжаагийн "Саран хөхөө" жүжгийн зохиолын шинжлэл, бичвэр судлал" ном "Дорно дахины уран зохиол" (1997, 2003, 2010, 2014) "Өрнө дахины уран зохиол" (2006, 2010) Их сургуулийн сурах бичиг бичсэн. "Өрнө дахины уран зохиолын дээж бичиг" ном эмхэтгэл хэвлүүлсэн "Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл", "Сүн улсын хүйтэн уулын бичиг", "Улаан асрын зүүд", "Тан улсын яруу найраг", зэрэг номын монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлсэн. Монголын орчин үеийн жүжгийн зохиол "Саран хөхөөний намтар" жүжгийн судлалаар монголд болон гадаадад 70 гаруй өгүүлэл хэвлүүлсэн.

1.21.СОДНОМЫН ЦОЛМОН

Шинжлэх ухааны салбарт 40 гаруй жил ажиллахдаа Монголын дундад үеийн түүхийн чиглэлээр дагнан 30 гаруй жил, ялангуяа Чингис хаан судлал, Их Монгол Улсын түүхийг нарийвчлан судалж, "Монгол Улсын түүх", "Их Монгол",



Түүхийн ухааны доктор, профессор Сономын ЦОЛМОН /Түүх/

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

“Монголын алтан ордны улс”, “Чингис хааны эзэнт гүрэн”, “Их Монгол Улсын өртөө, зам харилцаа”, “Монголын үндэсний нэвтэрхий толь”, “Монгол Улсын Үндэсний атлас”, “Чингис хааны өв”, “Хубилай хаан ба түүнийг залгамжлагч хаад”, “Монголын эзэнт гүрэн”, “Эрт, дундад үеийн евразийн сүлжээн дэх Монгол орон” зэрэг суурь судалгааны томоохон бүтээлүүдэд зохиогч, хамтран зохиогчоор ажиллаж, энэ чиглэлээр эрдэм шинжилгээний олон арван өгүүллэгийг дотоод, гадаадад хэвлүүлж, эрдэм шинжилгээний хурлуудад тогтмол илтгэл хэлэлцүүлж, олон улсад үнэлэгдсэн хөдөлмөр зүтгэл, “Монголын нууц товчоо”-г дэлхий нийтэд түгээхэд дорвитой хувь нэмэр оруулсан.

1.22.ТОЙТОГИЙН ТӨМӨРХҮЛЭГ

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ахмад дипломатч, нэрт орчуулагч, түүхийн ухааны доктор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд. Т.Төмөрхүлэг нь Вольтер, Шарль де Монтескье, Дени Дидро, Ги де Мопассан, Антуан де Сэнт-Эксюпери, Альбер Камю



зэрэг Францын үе үеийн алдарт зохиолчдын сор болсон олон арван бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлж, монгол уншигчдын хүртээл болгохын зэрэгцээ “Цогт тайж”, “Ингэн нулимс” зэрэг киног франц хэлнээ хөрвүүлсэн манай нэрт орчуулагч хүн юм. Т.Төмөрхүлэг нь Монгол Улсын гадаад харилцааны салбарт атташегаас эхлээд Элчин сайд хүртлээ 34 жил үр бүтээлтэй ажилласан туршлагатай дипломатч. Монгол Улсаас хоёр удаа Алжир дахь ЭСЯ-ны нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байсан юм. 1991 -1996 онд Лаос улсад Элчин сайдаар ажиллаж байх хугацаандаа Тайландын Вант улс, Камбож улсын Элчин сайдын албыг давхар хашиж байжээ. Дараагаар нь Монгол Улсаас Франц улсад суух Элчин сайдын зөвлөхөөр томилогдон ажиллаж байв.

1.23.ТҮВДИЙН ДОРЖ

МУИС-д 1965 онд элсээд 1 жил суралцаад улмаар сурлагаараа шалгарч ЗХУ-ын Москвагийн Их сургуулийн эдийн засаг кибернетикийн мэргэжлээр



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

аспирантурт суралцах урилгатай 1971 онд төгсөж иржээ. Харин МУИС-д ирэхэд нь аспирантурт явуулахыг нь хойшлуулж Инженер-эдийн засгийн факультетын эдийн засаг удирдлага зохион байгуулалтын тэнхимд багшаар ажиллуулжээ. Түүнийг уг тэнхимийн эрхлэгч тэр үеийн манай нэртэй эрдэмтэн Л.Гүржав багш олзуурхан хүлээн авч, эдийн засаг математик загварчлал, эдийн засгийн кибернетик, удирдлагын шинжлэх ухааны үндэс хичээлүүдийг заалгахаар болсон түүхтэй эрдэмтэн юм. Өнөөдөр академич Т.Доржийн зөвлөхөөр болон удирдагчаар ажиллаж хамгаалуулсан 7 шинжлэх ухааны доктор, 28 боловсролын доктор байгаа нь түүнийг ямар түвшний эрдэмтэн гэдгийг батална. Мөн түүний эрдэм шинжилгээний бүтээл 45-д хүрсэн бол эрдэм шинжилгээний өгүүллүүд гэхэд 100 хол даваад байна.

1.24.ЦОГТ-ОЧИРЫН ИШДОРЖ

Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэнгийн судалгааны профессор. Ээж талаасаа Ренцэн дүүрэгч вангийн Наваан тайж, Дандаа тайжын охин, аав нь Гэлэнгүүдийн удмын хүмүүс аж. Олон улсын Монгол судлалыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, дэлхийн олон том Монголч эрдэмтэдтэй мөр зэрэгцэн хөдөлмөрлөж явсан хүн. Монголын түүх, орчин үеийн түүх бичлэгийн зам мөр гаргасан эрдэмтэн.



1.25.ЦЭДЭВИЙН ӨНӨРБАЯН

МУБИС-ийн багш, Хэл шинжлэлийн ухааны ахмад нэрт эрдэмтэн профессор Ц.Өнөрбаян нь 1967 онд МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын ангид элсэн суралцсан. 1971 онд төрөлх сургуулиа төгссөн. Түүнээс хойш 45 жил энэ сургуульд эрдэм ном зааж, монгол хэл, уран зохиолын салбарын сургалт судалгааны салбарыг удирдаж байна. Бие дааж, бусад эрдэмтэдтэй хамтарч гаргасан ном сурах бичгийн тоо гэвэл 40 гаруй. Монгол хэлний сургалт судалгаатай холбоотой номууд голдуу



бичиж, 100 шахам өгүүлэл бий. Тэрээр 1980-аад онд Унгар улсын Өтвөш Лорандын нэрэмжит Шинжлэх ухааны их сургуулийн Ази судлалын тэнхимд багшлахын зэрэгцээ эрдэм судлалын ажил хийж эрдмийн зэрэг амжилттай хамгаалан улмаар Монгол судлалын ажилд томоохон хувь нэмэрээ оруулж ирсэн байдаг.

1.26. ЧОЙСҮРЭНГИЙН ДАГВАДОРЖ

1942 онд Хөвсгөл аймгийн Мөрөн сумд төрсөн. МУИС-ийн Монгол хэл, уран зохиолын анги төгссөн. “Монголын уран зохиод дах ажилчин ангийн дүрийн хөгжил” сэдвээр хэлбичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан. МУИС-ийн МХСС-ийн Нүүдлийн Соёл Иргэншил



судлалын төвд багш, тэнхимийн эрхлэгчээр ажилласан. МУИС-ийн Профессор цолтой. Уран бүтээлээ 1966 оноос эхлэж “Цэргийн албаны гоо зүй”, “Утга зохиолын шүүмжлэлийн тухай” зэрэг ганц сэдэвт зохиол, “Номоос төрсөн бодол”, “Зохиолч, цаг үе, уран бүтээл” шүүмжлэлийн түүврүүд, “Монголын нэвтэрхий толь”, Дэлхийн уран зохиолын бага хураангуй толь”-д зохиогчоор оролцсон. 1988 оноос яруу найраг бичиж “Далийн цэцэг”, “Далайн цэнхэр салхи”, “Ээж минь дээ”, “Атга шоро”, “Сэтгэлийн амраг”, “Нугас алаг нүд”, “Сэтгэлийн эгшиглэн”, “Хотгойд аялгуу”, “Богд нь уулын сүндэл” номууд хэвлүүлсэн. Утга зохиолын шүүмжлэгчдийн олон улсын холбооны гишүүн. 1999 оны 1 дүгээр сарын 7 нд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн хэмээх алдар хүндэт цолыг хүртжээ.

1.27.ЭНХБАЯРЫН РАВДАН

Э.Равдан нь 1968 онд хуучин ЗХУ-ын Эрхүүгийн их сургуулийн орос-хэл уран зохиолын багшийн ангийг хэлшинжээч, орос хэл, уран зохиолын багш мэргэжлээр дүүргэжээ. 1968 онд тэрбээр Гэгээрэлийн яамны томилолтоор МУИС-ийн орос хэл, уран зохиолын мэргэжлийн тэнхимд багшаар томилогдон ажиллаж байгаад 1973 онд М.В. Ломоносовын



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

нэрэмжит Москвагийн их сургуулийн аспирантурт явж суралцсан байна. Э. Равдан 1976 онд ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнд хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Мөн оноос УДТДТМБХ-ны томилолтоор ХААДС-ийн орос хэлний тэнхимийн эрхлэгч, УДТДТМБХ-нд гадаад хэл эрхэлсэн мэргэжилтэн, ОБДС-д тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байгаад 1988 онд М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль дээр хэлний шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалжээ. 1986 онд Э. Равдан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох улсын комиссын шийдвэрээр Доцент цол, 1990 онд мөн комиссын шийдвэрээр Профессор цол хүртжээ. 1991 онд Э. Равдан өөрийн хүсэлтээр МУИС-д шилжин ирж, ОУХС-ийн тэнхимийн эрхлэгч, ГХСС-ийн захирлын үүрэгт ажлыг гүйцэтгэж байв. Одоо ШУС-ийн ХУС-ын Европ судлалын тэнхимд зөвлөх профессороор ажиллаж байна. Профессор Э.Равдан дээд боловсролын салбарт 50 шахуу жила жиллахдаа эрдэм шинжилгээнийнэг сэдэвт зохиол, толь бичиг, бүх шатны сургуулийн сурагчдад зориулсан сурах бичиг нийлээд 34, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 200 гаруйг бичиж туурвижээ. Тэрбээр гадаад, дотоодын нийт 20 гаруй хүний докторын, 30 –аад хүний магистрын зэрэг хамгаалах диссертаци, дипломын ажлын эрдэм шинжилгээний удирдагчаар ажилласан байна.

1.28. ЭРДЭНИЙН ПҮРЭВЖАВ

Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Пүрэвжав, 1993 хэл ярианы соёлын зарим асуудал” сэдвээр хэл бичгийн ухааны эрдмийн зэрэг хамгаалж, Монгол хэл бичиг судлалд, өөрийн гэсэн судалгааны шанг татсанаас хойш Монгол хэл бичгийн шинжлэх ухаан,




“Монголын нууц товчоо” судлал, Монгол судлалын чиглэлээр судалгааны ганц сэдэвт бүтээл, эх хэрэглэгдэхүүн, дээж бичиг, хамтын бүтээл, толь бичиг, эмхэтгэл, гарын авлага олныг гаргажээ. Доктор Э.Пүрэвжавын тэдгээр олон бүтээлээс, судлаачийн өөрийнх нь санаачилга, тиймээс судлаач зөвхөн өөрөө эрхлэн гаргадаг, доктор Э.Пүрэвжавын нэрийн хуудас болсон “Монгол хэл бичгийн судлал” цуврал нь онцлог билээ. Анх 1997 онд эхлэн

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

нийтэлснээс хойш өдгөө хүртэл тасралтгүй үргэжилсээр байгаа билээ. Энэ бүтээл Монгол хэл шинжлэлд үнэтэй хувь нэмрээ оруулсан, өөрийн байр сууриа эзэлсэн, ном бүтээлээ гаргасан гурван эрдэмтэн, судлаачийг сонгон, тэдний амьдрал үйлс, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд нь үнэлэлт өгөөд, төгсгөлд нь тухайн судлаачийн бүтээлийн бүрэн цэсийг, хамгийн чухал гэж үзсэн нэг зохиолынх нь хамт оруулж өгдөг нь, нэг талаас тусгайлан судалсан асуудлыг нэгтгэснээрээ, нөгөө талаас орчин цагийн монгол хэл шинжлэлийн хөгжлийн түүхэн тоймыг гаргахад бодит үр дүнгээ өгч буй, чухал ач холбогдолтой бүтээл болдог юм. Доктор Э.Пүрэвжав, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнаас, хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга болж, улмаар энэ завсар Японы Гадаад судлалын их сургууль болон бусад их дээд сургууль, судалгааны төвд “Зочин профессор”-оор олон жил ажиллаж, Монгол судлалыг олон улсад түгээх, харилцаа холбоо тогтоон ажиллахад, олон улсын монгол судлаач эрдэмтдийн их хурал, чуулга уулзалтыг зохион байгуулахад эрдэм чадал, хөдөлмөр зүтгэлээ чамгүй зориулжээ.

1.29 . АНДРАШ РОНА-ТАШ (Унгар Улс)

Монголч эрдэмтэн, Унгарын нэрт эрдэмтэн Андраш Рона-Таш Унгарын нэрт эрдэмтэн акадেমич, түүхч, хэл шинжээч, судлаач, Монголч эрдэмтэн юм. Тэрээр Диула Ортутай-Gyula Ortutay , Lajos Ligeti Лайош Лигети тэргүүлэх профессор нарын удирдлагын дор суралцан, ардын аман зохиол, түвд, монгол, турк болон зүүн европ хэл шинжлэл, судлалаар эрдэмийн зэргээ анх хамгаалсан байна. Монголд анх 1957-1958 онд айлчилан, хөдөө нутагт,



хүн амын аж ахуй амьдралтай танилцан, зан заншил, хэл соёл, ардын аман зохиол, хөдөө, мал аж ахуйн амьдралын судалгааг хийсэн байна. Түүнээс хойш удаа дараалан монголд айлчлан судалгаа бүтээлээ улам ихээр арвижуулжээ. Монголын нүүдэлчдийн мөрөөр, (1968-1970) 2014 онд орос хэл дээр хэвлэгдсэн, Түвд Монголд дахин зочилсон нь (1982-1989) гэсэн олон сайхан ном бүтээлүүд туурвин, монгол орныг, ард түмэн ахуй амьдралтайн сайн судалласан байх юм.

Тэр үед үнэхээр сайн оновчтой тодорхой судалгааг биечлэн аялан нарийн нягт нямбай хийдэг байсан нь үнэхээр гайхалтай.

1.30. ГРАЙВОРОНСКИЙ ВЛАДИМИР ВИКТОРОВИЧ (Оросын Холбооны Улс)

Грайворонский Владимир Викторович бол Монгол судлалд 60 шахам жилийн ажил амьдралаа зориулж яваа ОХУ-ын нэрт монголч эрдэмтдийн нэг юм.

Тэрээр 1954 онд Москвагийн Олон Улсын харилцааны дээд сургуульд элсэн орсон. Тэнд Дорно дахины факультетын Монгол судлалын ангид элссэн. 1960 онд сургуулиа төгсөөд Комсомолын дээд сургуульд монгол хэлний орчуулагчаар 1966 он хүртэл ажилласан. 1966 онд тэр үеийн Азийн орнуудын институтд ажилд орсон. 1975 онд “ Нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдрал руу шилжих нь БНМАУ-ын жишээн дээр” гэсэн сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. Докторын зэргийг “Ойрдын нийгмийн тулгамдсан асуудлууд 1970 -аад оны дунд үе хүртэл” сэдвээр хамгаалсан. Тэрээр Монгол дахь ЗХУ -ын Элчин сайдын яаманд Гадаад явдлын яамны томилолтоор ЭСЯ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга, Зөвлөх зэрэг албан тушаалд хоёр удаа томилогдож, нийт 10 жил ажилласан. Соёл, боловсрол, эрүүл мэнд,спортын асуудал хариуцан ажиллаж байлаа. Монголд 1982-1988 онд, хоёр дахь удаагаа 1996-2000 онд дипломатаар ажилласан. Түүний судалгаанд Монголын шинэхэн түүх, Орчин үеийн Монголын улс төр, нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, Орос-Монголын харилцаа чухал байр суурь эзэлдэг. Тэрбээр өнгөрсөн хугацаанд дээрх сэдвээр 130 гаруй судалгаа шинжилгээний бүтээл туурвижээ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛАЛЫН ОЛОН УЛСЫН ХОЛБОО БОЛОН МОНГОЛ СУДЛААЧИДТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГҮҮД, ЗАХИДЛЫН ЭМХЭТГЭЛ

Олон улсын монголч эрдэмтдийн V их хурал 1987 оны 9 дүгээр сарын 14-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хуралдаж гучин зургаан орны 300 орчим эрдэмтэд оролцсон байна. Тус хурлын үеэр Олон улсын монголч эрдэмтдийн их хурлын Байнгын Хороог өргөтгөн “Олон Улсын Монгол Судлалын Холбоо”-г байгуулж, тогтмол үйл ажиллагаатай төрийн бус байгууллагыг байгуулсан билээ. Олон Улсын Монгол Судлалын Холбооны ерөнхийлөгчөөр Америкийн нэрт монголч эрдэмтэн О.Латтимор, ерөнхий нарийн бичгийн даргаар Монгол улсын нэрт эрдэмтэн Ш.Бира нар сонгогдож байсан. Энэ үеэс эхлэн Олон Улсын Монгол Судлалын Холбоонд дэлхий дахинд нэртэй олон монгол судлаач эрдэмтдийн захидал бичиг, тэдэнд тус холбооноос бичсэн захидал, дэлхийн олон оронд буй монгол судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвүүдээс тус холбоонд илгээсэн захидал, албан хүсэлт зэрэг хувь хүн, байгууллагуудаас ирсэн, явуулсан захидал, бичгүүд хуримтлагдан хадгалагдаж байна.

Захидал, бичиг нь түүхийн судалгааны эх сурвалжийн нэг төрөл бөгөөд ялангуяа хувь хүн, намтар судлалын үндсэн хэрэглэгдэхүүн болдог билээ. Үүнээс гадна алба захидал бичсэн хувь хүний мэдлэг, судалгааны цар хүрээг илтгэн харуулж чадах нэг үзүүлэлт юм. Харин албан байгууллага хоорондын албан ёсны албан бичиг, захидлууд нь тухайн байгууллагын үйл ажиллагааны гол чиглэл, судалгааны хандлага, хамран цар хүрээ, төлөвлөлт, тухайн нийгмийн байдал зэргийг харуулж байдаг. Тийм учраас Олон Улсын Монгол Судлалын Холбоонд хуримтлагдсан хадгалагдаж буй олон арван захидлаас түүвэрлэн эмхэтгэн нийтлүүлж байна.

Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага Судар бичгийн хүрээлэнг 1921 оноо байгуулж, монголыг судалдаг олон хүмүүстэй харилцаа тогтоож, хамтран ажиллах, ном судар солилцох ажлыг эхлүүлсэн билээ. Тийм учраас зөвхөн Олон Улсын Монгол Судлалын Холбоог байгуулсан цаг үеийг хамруулах бус Монгол улсын эрдэм судлалын байгууллагаас албан ёсоор олон улсын эрдэмтэдтэй харилцаж эхэлсэн цаг үе буюу 1922 оноос эхлүүлэн 2000 он хүртэл ная гаруй жилийн хугацаан дахь монголч эрдэмтдийн захидал бичгийг хамруулан авч үзлээ.

Монгол Улсын Ардын Засгийн газраас байгуулсан Судар бичгийн хүрээлэн 1922 оноос Зөвлөлт Орос Улсын Шинжлэх Ухааны Академитай харилцаа тогтоох албан захидал бичиг илгээж, “Гэсэрийн тууж”-ийг нэг эхийг бэлэг болгон илгээж байжээ¹. Энэхүү захидлыг Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Академиас талархан хүлээн авч, албан ёсны харилцаа хамтын ажиллагааг эхлүүлсэн байна. Ялангуяа Зөвлөлтийн ШУА-ийн байнгын нарийн бичгийн дарга, дорно дахин судлаач С.Ф.Олденбург, Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн нар чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1925 оны 1 дүгээр сард ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн газрын дэргэд Монгол ба Тагна Туваг шинжлэх ухааны үүднээс судлах комисс [Монголын комисс]-ыг байгуулсан байна. Комиссын үйл ажиллагаа улам өргөжсөн учраас ШУА-д шилжүүлсэн. Энэ комиссоос Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулж, шинжлэх ухааны бүхий л чиглэлээр Монгол улсад судалгаа хийж байв. Энэ үеэс Зөвлөлтийн шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулийн монгол дахь судалгааны ажлыг “Монголын комисс”-оос удирдан зохион байгуулж, Судар бичгийн хүрээлэнтэй харилцах болсон. Эмхэтгэлийн эхний хэсэгт Монголын комисс, Судар бичгийн хүрээлэнгийн харилцааг илтгэсэн бичиг, захидал голлож байна.

Судар бичгийн хүрээлэнгээс дан ганц Зөвлөлтийн эрдэмтэдтэй харилцаж байсангүй. Герман, Франц, АНУ, Польш, Финланд зэрэг улсын эрдэмтэдтэй харилцаа тогтоон тухайн үеийн монгол судлалын голлон эрдэмтэдтэй харилцаж ном судар солилцох, цуглуулах ажлыг хийж, хамтарсан судалгаануудыг эхлүүлж байв.

Монгол улс ба хөрш зэргэлдээ улсад буй монгол туургатан ах, дүү нартай харилцаа тогтоох, монгол хэлээр ном, судрыг олж авах, солилцох ажлыг хийх, олон хүмүүстэй бичиг захидлаар харилцаж байв. Ялангуяа Дундад Иргэн Улсад байсан монголчуудтай харилцаа тогтоож, ном судар цуглуулж байсны хамгийн чухал үйл явдал нь Бээжинд амьдарч байсан Халхын чин ван Наянтаас Цахар дахь Шашныг бадруулагч сүмд хадгалагдаж байсан түүний мэдлийн “Данжуур”-ын 226 боть хөлгөн судрыг Монгол улсад залж авчирсан явдал юм². ЗХУ-ын бүрэлдэхүүнд үлдсэн Буриад-Монголын Эрдмийн хүрээлэн, түүнийг удирдаж байсан Б.Барадин, Г.Цыбиков нартай харилцаа тогтоож,

¹ МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-7, т.47

² МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-58, т.86-26

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

хамтарсан судалгаа эхлүүлж, эхний үр дүн түрүүчээ хэвлэгдэж байсныг захидал бичгүүдээс харж болж болохоор байна.

Энэ мэтчилэн Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагааны цар хүрээ маш өргөн байж, тухайн цагт мэдэгдэж байсан харилцах боломжтой бүхий л судлаач, эрдэмтэн, байгууллага, ном судар цуглуулагч нартай харилцаа тогтоож бичиг, захидлаар харилцаж байжээ.

1930 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Судар бичгийн хүрээлэн хэмээх нэрийг Шинжлэх ухааны хүрээлэн болгон өөрчилжээ³. Энэ үеэс БНМАУ-ын улс төрийн нөхцөл байдлаас хамаарч Шинжлэх Ухааны хүрээлэнгийн гадаад харилцаа хумигдаж, зөвхөн ЗХУ-ын шинжлэх ухааны байгууллагуудтай харилцах болсон. Зөвлөлтийн ШУА-ийн “Монголын комисс”-ын үйл ажиллагаа эрчимтэй байж, БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэн дээр тулгуурлан судалгааны явуулж байв. Энэ үед байгалын ухааны чиглэлийн судалгаа шинжилгээний ажил өргөжин тэлж, монгол залуус ЗХУ-ын их, дээд сургуульд амжилттай суралцаж, анхны эрдэмтэд буй болсон үе юм. Тийм учраас Шинжлэх ухааны хүрээлэнгээс Зөвлөлтийн ШУА болон олон хүрээлэнгүүдтэй харилцаж байсан бичиг, захидлаас түүвэрлэн оруулсан болно.

1950-иад оны сүүлчээр Шинжлэх Ухаан Дээд боловсролын хүрээлэн дээр төвлөрөн олон улсын монголч эрдэмтдийг Улаанбаатар хотод нэг доор цуглуулан олон улсын эрдэм шинжилгээний их хурал зохион байгуулах ажлыг эрчимтэй хийсний үр дүнд 1959 онд “Олон улсын монгол хэл, бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал” нэртэйгээр зохион байгуулжээ.

Энэ хурлын ач холбогдол нь зөвхөн ЗХУ тэргүүтэй социалист орнуудын эрдэмтдээс гадна тухайн үед капиталист хэмээн нэрлэж байсан АНУ, Англи, Франц, Япон зэрэг олон улсын монгол судлаач эрдэмдийг нэг доор цуглуулж, цаашид монгол судлалын талбар нь БНМАУ мөн болохыг олон улсад харуулсан юм. Энэ үеэс эхлэн БНМАУ-ын шинжлэх ухааны байгууллагын гадаад харилцаа, тэр дундаа монгол судлалын үйл ажиллагаа өргөжин тэлсэн байна. Урьд өмнө нь гадаадын монголч эрдэмтэд Монгол улсад дангаараа болон монголчуудыг дагалдуулан судалгаа хийдэг байсан бол энэ үед БНМАУ-д нэгэнт монгол судлалын үндсэн чиглэлүүд болон түүх, хэл, соёлын чиглэлийн үндэсний

³ МУУТА. ТБА. Х-1. Д-2, ХН-402. т. 281

эрдэмтэд нэгэнт буй бол хамтарсан судалгааны ажлыг хийх түвшинд хүрсэн байв. Тиймээс энэ үеэс эхлэн Монгол улсын шинжлэх ухааны байгууллагат хандаж буй монгол судлаач эрдэмтдийн чиг хандалага өөрчлөгдөж, хамтарсан судалгаа хийх, судалгааны эх сурвалж цуглуулах, залуу монгол судлаачдыг бэлтгэхэд БНМАУ чухал болохыг олон улсад харуулж чадсан байна.

БНМАУ-ын улс төрийн дэглэм болон гадаад харилцааны бодлогоос хамаарч тухайн үеийн капиталист хэмээх улсын монголч эрдэмтэдтэй шууд харилцах явдал хязгаарлагдмал байв. Тиймээс БНМАУ-ын соёлын бодлогын хүрээнд Гадаад харилцааны яамаар дамжуулан харилцаж байжээ. Энэ үеийг илтгэх бичиг, захидал, дипломат албаны баримтаас харж болох учраас Гадаад Харилцааны Төв Архивт буй баримтаадаас төлөөлүүлэн орууллаа. Үүнд, Английн эрдэмтэн Ч.Бауден, Америкийн эрдэмтэн О.Латтимор нарын холбоотой баримтуудыг дурдаж болно.

“Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал”-ыг зохион байгуулсны дараа тус их хурлыг таван жил тутам нэг удаа зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Гэвч тухайн үеийн олон улсын улс төрийн нөхцөл байдал, дэлхийн улсуудын хоёр системийн хуваагдал, дотоодод болж өнгөрсөн “Сэхээтний төөрөгдөл”, “Лоохууз, Нямбуу, Сурмаажав” нарын намын эсрэг бүлэг гэгч үйл явдал Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэсэн үйл явдал, түүний дараах олон Д.Төмөр-Очирын толгойлсон намын эсрэг явуулга зэрэг улс төрийн зохиомол хэргүүд гарч шинжлэх ухааны гадаад харилцаа хэсэг хугацаанд зогсонги байдалд оржээ. Тиймээс энэ үеийн монголч эрдэмтдийн бичиг захидал цөөн байна.

Олон Улсын Монголч Эрдэмтдийн II их хурлыг ШУА-иас санаачлан 3 жилийн хугацаанд бэлтгэж ажлыг хангаж 1970 онд зохион байгуулсан. Тус хуралд, Австрали, Англи, АНУ, Финлянд, Франц, ХБНГУ, БНАГУ, ЗХУ, Болгар, Польш, Румын, Унгар, Чехословак, Энэтхэг, Япон, Монгол зэрэг 24 орон, олон улсын хоёр байгууллагыг төлөөлсөн 120 гаруй эрдэмтэд оролцож, “Хэл, утга зохиол”, “Түүх, эдийн засаг” гэсэн хоёр салбар хуралдаанд 110 орчим илтгэл хэлэлцүүлжээ⁴.

Олон улсын монголч эрдэмтдийн II их хурлын төлөөлөгч О.Латтиморийн саналаар “Олон улсын монголч эрдэмтдийн их хурлын байнгын хороо”-г байгуулж, ерөнхийлөгчид Монгол Улсын ШУА-ийн ерөнхийлөгч Б.Ширэндэвийг, дэд ерөнхийлөгчид Л.Лигети

⁴ МУУТА. ТБА. х.23, д.2, хн.632. т. 5-16

(Унгар), Е.Жуков (ЗХУ), Р.Рахул (Энэтхэг), Ф.Бурхард (АНУ), Ерөнхий нарийн бичгийн даргаар С.Лувсанвандан, нарийн бичгийн даргад Д.Кара, Х.Гомбожав, П.Фитце, М.И.Гольман, О.Өргөнгөө, Регалофф нарын сонгожээ⁵. “Олон улсын монголч эрдэмтдийн их хурлын байнгын хороо”-г Монгол улсад байгуулснаар монгол судлаач эрдэмтэдтэй харилцах харилцаа өргөжин Монгол улсад хандах эрдэмтдийн нэмэгдсэн байна. Тус хорооноос “Олон Улсын Монголч эрдэмтдийн III, IV, V их хурлыг амжилттай зохион байгуулсан. Энэ үеэр гадаадын монголч эрдэмтэдтэй харилцах байдал улам сайжирчээ. Ялангуяа АНУ-д монгол судлалыг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Хангин Гомбожав, Английн монгол судлалыг хөгжүүлсэн Онон Өргөнгөө, Германы Хайссиг нарын идэхтэй үйл ажиллагаа, тэдний монголчуудтай харилцаж байсан олон сонирхолтой захидлууд дурдаж болно

1987 онд Олон улсын монголч эрдэмтдийн V их хурлын үеэр Олон Улсын Монголч эрдэмтдийн байнгын хороо байгуулагджээ. Энэ үеэс тус хорооны үйл ажиллагаа идэвхжиж, гадаад монгол судлаач эрдэмтэдтэй тогтмол харилцах болжээ. Энэ үеэс “Олон Улсын Монгол Судлалын холбоо”-г удирдах болсон Японы монголч эрдэмтэн Ш.Озава, Ерөнхий нарийн бичгийн дарга академич Ш.Бира нарын харилцаж байсан сонирхолтой захидлуудыг оруулсан.

Монгол судлалын үндсэн чиглэлүүдийн нэг нь түүхийн судлал билээ. Тиймээс ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн баримт мэдээллийн сан дахь монголч эрдэмтдийн захидал бичгээс түүвэр зарим сонирхолтой захидлыг эмхэтгэлд оруулсан юм. Тухайлбал, тус хүрээлэнгийн захирал академич Ш.Нацагдоржид бичсэн АНУ-ын эрдэмтэн О.Латтимор, Германы эрдэмтэн Хайссег, Зөвлөлтийн эрдэмтэн Златкин, Польшийн эрдэмтэн Вероника нарын захидлыг хэлж болно.

1990 оноос Монгол улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжиж, гадаад улс оронтой чөлөөтэй харилцаж эхэлсэн. Тиймээс БНМАУ-ын хилийн гадна үлдсэн ах, дүү өвөр монголчууд ОУМСХ-оор дамжуулан, Монгол улсад ирж судалгаа хийх, Монгол Улсын эрдэмтдийн судалгааны үр дүнтэй танилцах явдал нэлээд өргөн хүрээтэй явагдсан байна. Тиймээс энэ үеэс өвөр монголчуудаас ОУМСХ-д хандсан олон захидлуудаас түүвэрлэн багтаасан. Энэ үеэс захидал харилцаа цахим хэлбэрт шилжиж эхэлснээс

⁵ МУУТА. ТБА. х.23, д.2, хн.630. т. 25-36

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

шалтгаалан цаасан суурьтай захидал багассан байна. Тиймээс албан бичиг, баримт үлдэж, хувь хүний захидал багасжээ.

Гадаад, дотоодын олон эрдэмтэн, судлаачдыг захидал бичгийг “Олон Улсын Монгол Судлалын Холбоо”-ны сан хөмрөг дэх захидал, бичгүүд дээр тулгуурлан Монгол Улсын Үндэсний Төв архив, Гадаад харилцааны төв архив, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн баримт мэдээллийн сан дахь захидал бичгүүдээр баяжуулан 453 захидлыг эмхэтгэн хэвлүүлж байна. ОУМСХ-ны архиваас 199 баримт, Үндэсний төв архиваас 188, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн 53 баримт, ГХТА 13 баримт бичиг захидлыг хамруулан оруулжээ. Эдгээр захидал бичгийн 242 нь монгол хэлээр, 120 нь орос хэлээр, 86 англи хэлээр, 5 нь герман хэлээр бичсэн захидал бичиг болно.

Энэхүү эмхэтгэлд багтсан монголч эрдэмтдийн бичиг захидал нь Олон Улсын Монгол Судлалын Холбооны үйл ажиллагааг илтгэн харуулахаас гадна ХХ зууны Монгол Улсын шинжлэх ухааны салбарын гадаад харилцаа, гадаадын монголч эрдэмтдийн Монгол улстай харилцаж байсныг тодруулахад чухал эх сурвалж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ СУДЛАЛЫН ХУРЛУУД

3.1. “ЗАЛУУ МОНГОЛ СУДЛААЧДЫН МОНГОЛ СУДЛАЛ БА ӨНӨӨ ҮЕ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Монгол Улсын ШУА-ийн залуу судлаачид санаачлан монгол судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, номын сан, архив, музейн залуу судлаачдыг нэгтгэн “Залуу монгол судлаачдын “ЭРДМИЙН ХЭЛХЭЭ” нийгэмлэг” ТББ-ыг 2022 оны эхээр үүсгэн байгуулсан билээ. Залуу судлаачдын нийгэмлэгийн гол зорилго нь Монгол Улсыг монгол судлалын гал голомт байхад хувь нэмрээ оруулах, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаанд залуу судлаачдын оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжих юм.

Залуу монгол судлаачдын “ЭРДМИЙН ХЭЛХЭЭ” нийгэмлэг”-ээс зохион байгуулсан “Залуу монгол судлаачид: Монгол судлал ба өнөө үе” эрдэм шинжилгээний хурал 2022 оны 05 сарын 28- ны өдөр ШУА-ийн Их чуулганы танхимд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Хурлын үйл ажиллагааг нээж ЗМСЭХН-ийн тэргүүн М.Энхбаатар, БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга доктор (Ph.D) Д.Баттогтох, ШУА-ийн Эрдэм шинжилгээ мониторингийн хэлтсийн дарга доктор (Ph.D) С.Баяннасан, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал доктор (Ph.D) Ц.Цэрэндорж, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал доктор (Sc.D) Ж.Бат-Ирээдүй, МБШТГТХ-ийн дэргэдэх Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын бурхны шашны дээд сургуулийн дэд захирал Б.Жамбал нар үг хэлэв.

Эрпэм шинжилгээний тус хуралд гадаад, дотоодын 50 гаруй судлаачид оролцож, илтгэл хэлэлцүүлсэн юм. Тус хурал нь:

1. Эх хэл, утга зохиол, урлаг, шашин соёлын асуудал,

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

2. Эх, түүх, эртний судлал, угсаатан соёлын харилцааны асуудал гэсэн 2 салбар хуралдаанд нийт 49 илтгэл хэлэлцүүлээ.

Хурлыг илтгэгч нар нь салбар бүрдээ эрдмийн зэрэг горилон ажиллаж буй залуучууд байв. Сүүлийн жилүүдэд судалгааны чиг хандлага нь салбар дундын ба салбар дамнасан чиглэлүүд илүүтэй давамгайлж байна.

Эрдэм шинжилгээний хурлыг Боловсрол, Шинжлэх ухааны яам, Шинжлэх Ухааны Академи, түүний харьяат нийгмийн ухааны 5 хүрээлэн, МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Талын язгууртан сан, Архивын ерөнхий газар, Үндэсний төв номын сан, Монголын үндэсний музей, Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Монголын бурхан

төв



шашинтны

Гандантэгчинлин хийд, Мөнхийн урлаг эртний эдлэлийн галерей зэрэг байгууллага, хувь хүмүүс дэмжин ажиллалаа.

Монгол судлалын хүрээн дэх залуу судлаачдад туслгамдаж буй асуудал бэрхшээлүүд тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, хийж хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар хэлэлцсэн үр дүнтэй хурал болсон.

Хурлын илтгэгчид 2022 оны 5 сарын 28

3.2. “МОНГОЛ СУДЛАЛ БА МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО: СУДАЛГААНЫ БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА” ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТДИЙН



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Дотоод Азийн бүс нутаг дахь Монгол судлал: бичгийн болон аман түүхийн сан хөмрөг бүрдүүлэх, шинэ хандлагыг тодорхойлох нь” суурь судалгааны төслийн хүрээнд МОНГОЛ СУДЛАЛ БА МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО: судалгааны байдал, ирээдүйн чиг хандлага олон улсын монголч эрдэмтдийн хэлэлцүүлгийг 2022 оны 8 дугаар сарын 12, 13-нд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэнгийн Хөдөө аралд зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт Д.Рэгдэл Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч, академич С.Чулуун Олон Улсын Монгол Судлалын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, академич Ц.Цэрэндорж ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, доктор Г.Эрэгзэн ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал, доктор Хөхбаатар Япон улс, Шова их сургууль. Доктор А.Пунсаг. Монгол улс. ШУА-ийн Түүх, Угсаатны хүрээлэнгийн ЭША Э.Пүрэвжав. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША, доктор Ким Жан Гү. БНСУ, монгол судлаач, доктор Н.Саруул. Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн захирал, доктор нар оролцлоо.

Хэлэлцүүлэгийн үеэр 2023.08.12-13

3.3. “МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

“Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” сэдэвт зургаа дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурал 2023 оны 4 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Чингис хаан музейд боллоо. Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор Монгол улсын ШУА-ийн түүх, угсаатны зүйн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Чингис хаан үндэсний музей хамтран зохион байгуулж байна. Улаанбаатар, Санкт-Петербург хотноо 2013 оноос эхлэн хоёр жил тутам ээлжлэн зохион байгуулагдаж ирсэн уг хурал нь дэлхийн улс орнуудад хадгалагдаж байгаа Монголын түүх, соёлын дурсгалуудыг судлах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж танилцуулах, хамтран хэвлэн нийтэлж түгээн сурталчлах, судалгааны цар хүрээг өргөжүүлэн тэлэх, олон улсын эрдэмтдийн хүчин чармайлтыг нэгтгэн цогц судалгаа явуулахад чиглэсэн хамтын ажиллагааны чухал арга хэмжээ юм. Энэ удаагийн хуралд Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Чингис хаан Үндэсний музей, МУИС, МУБИС, Үндэсний төв архив, Богд хааны Ордон музей; ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн (Санкт-Петербург), Эдийн соёлын түүхийн хүрээлэн (Санкт-Петербург), Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвөд, буддын судлалын хүрээлэн (Улаан-Үд), ОХУ-ын Халимагийн улсын их сургууль, “Улсын Эрмитаж” музей, Оросын Угсаатны зүйн музей, ОХУ-ын Бүгд найрамдах Татарстан улсын Казаны их сургуулийн эрдэмтэд оролцлоо. Мөн Казаны Түүх, соёлын өвийг дэмжих “Палладий” сан, Унгар улсын Төв Европын их сургууль, Өтвөш Лорандын Их сургууль, БНХАУ-ын Өвөр Монголын их сургууль зэрэг Монголын түүх, соёл, хэл уран зохиол, монгол судлалын салбарт судалгаа явуулдаг 21 байгууллагын 30 гаруй эрдэмтэн судлаачид биечлэн, 15 эрдэмтэн, судлаач цахимаар оролцож илтгэлээ хэлэлцүүлэв.

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Хурлын зорилго нь Монгол Улс, ОХУ, БНХАУ, Унгар, ХБНГУ, Солонгос зэрэг улсад хадгалагдаж байгаа гар бичмэл, сурвалж бичгүүд, монгол судлаач эрдэмтдийн сан хөмрөг, бүтээл туурвил, Монголын хэл, түүх, соёлын асуудлуудыг судлан шинжилсэн, шинэ баримт, эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцэж, судалгаа шинжилгээний өнөөгийн төлөв байдлын талаар санал солилцох, цаашдын хандлага, цар хүрээг тогтоох, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэхэд орших ажээ.



Хурлын нээлт 2023.04.23

ДҮГНЭЛТ

Дэлхийн Монгол судлалын төвүүд уламжлалт хэл, түүхийг судлах ажиллагаанд төвлөрөхөөс гадна нийгэм соёлын хүн судлал, археологи, эдийн засаг, орчин үеийн улс төрийн байдлыг судлах явдал ихэссэнээс гадна дан ганц Монгол Улсыг бус бүс нутгийн хэмжээнд анхааран судлах явдал идэвхжиж байна. Үүнтэй холбоотойгоор Монголч эрдэмтдийн сан үүсгэх хэрэгцээ гарч ирсэн. Энэхүү мэдээллийн сан нь аман түүхийн онцгой нэгэн баримт болон үлдэж байна. Ирээдүй хойч үеийн судлаач нарын хэрэгцээт материал болно гэдэгт итгэлтэй байна.

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Олон улсын Монгол судлалын холбооноос хэрэгжүүлсэн Дотоод Азийн бүс нутаг дахь Монгол судлал:Бичгийн болон аман түүхийн сан хөмрөг бүрдүүлэх, шинэ хандлагыг тодорхойлох нь суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсын Төв Архив, Гадаад харилцааны архив, Олон Улсын Монгол Судлалын холбооны архив, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн баримтын санд хадгалагдаж буй монгол судлалтай холбоотой захидал бичиг, тушаал шийдвэр зэрэг түүхэн баримтуудыг эмхэтгэн нийтлүүллээ. Уг баримтууд нь Монгол Улсад Үндэсний Монгол судлал хөгжиж эхэлсэн 1922 оноос улбаатай бөгөөд хүйтэн дайны үед ч хана хэрэм нэвтэлж харилцаж чадаж байсан эрдэмтэн судлаачдын харилцаа, 1990-ээд оны ардчиллын үйл явцын үр дүнд дахин сэргэсэн монгол судлалын түүхийг танин мэдэхэд боломжийг олгох баримтууд гэж үзэж байна. Монгол судлалын түүхийг судлагч, монгол судлалын аливаа түүхэн асуудлаар судалгаа хийж буй хэн бүхэнд чухал гарын авлага болох боломжтой баримтын эмхэтгэл юм.

ХАВСРАЛТ 1.

Дотоод Азийн бүс нутаг ба “Монгол судлалыг шинээр харах нь”

С.Чулуун

Оршил.

Монголын шинжлэх ухааны салбаруудаас өөрийн онцлогт суурилсан шинжлэх ухааны судалгааны үндсэн объект болгон авч яваа цөөн салбарын нэг нь түүхийн судалгааны чиглэл юм. Түүний ерөнхий арга зүй, онолын хандлагыг харвал суурь ухааны нэг мэт боловч “Монголын судлал” (Mongolistic, Mongolovedenie), хэмээх нэгэн бие даасан судлалын цөм нь болж явдгаараа онцлогтой. Дэлхийн түүхийн судалгааны чиглэл, бүс

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

нутгийн судалгааны онцлогоос хамаарч энэ судалгаа ямар боловч 100 гаруй жилийг туулсан. Өвөрмөц, соёл, ахуй байдлын талаар онцлогтой монголчуудын хэл соёл, түүхийн судалгаа нь эхэндээ мэдээж “дорно дахин судлал” буюу “орениалист”-уудын хүрээнд өрнөж, аажимдаа өрнө хийгээд дорнын ард түмний шинжлэлгээ судалгаанд харьцангуй бие даан хөгжих үүд нээгдсэн. Монголын судлал нь өнгөрсөн ихэнх цаг хугацааны туршид монголыг хариас харах, тэдний нүдээр үзэх “*прадигма*” болон хөгжсөөр ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Өрнө дахины хувьд эрдэмтэд төдийгүй олон нийт нь

“монгол туургатнаас бараг бүрнээ тасархай, тэдэнтэй шинжлэх ухааны болон соёлын ямар нэг дорвитойхон холбоо байхгүй, цаг үеийн баттай мэдээлэл тулгуур ном зохиол, суралцах бичиг, хээрийн шинжилгээний эх материал онцгой дутагдаж байснаас гадна хэт өрнөдийн үзэл “евроцентризм”-ын чиглэлтэй”

байсан бол дорно дахины улсуудад

“Монголчуудыг соёлын өөр ертөнц, (энэ нь харьцангуй хоцрогдсон бүдүүлэг хэлбэр), их үндэстний зах хязгаарын нутаг, амьдралын хэв маягийн эртний хэв шинж гэх зэргээр “харьчлах” хандлага”

илүүтэй байсан юм. Өөрөөр хэлбэл монгол нь өрнөдийн хувьд дорно, дорнын хувьд зах хязгаар гэсэн агуулга тээх болсон юм. Үүнийг орчин үеийн монголын судлалын үндэс байсан гэж үзэж болно. Харин өнгөрсөн зууны эхэн хагасаас дээрх хандлагад зарим өөрчлөлт гарч эхэлсэн. Энэ бол Японы эрдэмтдийн хандлага байв. Тэд өөрийн хүчтэй өрсөлдөгч дорно дахин болох Хятадын түүхийг авч үзэхдээ түүний умардад орших хөрш нүүдэлчдийн түүхийг салгаж авч үзэх, цагаан хэрмээс хойших нүүдэлчдийг “умардын нүүдэлчид”, “Евроазийн түүх”, цагаан хэрмийн гаднах ард түмний түүх гэсэн хэд хэдэн нэрийтгэлийн дор нүүдэлчдийн түүхийг хятадын Хан үндэстний түүхээс тусдаа хэмээх прадиγμαар авч үзсэн. Энэ нь Монголын судлалыг дахин харахыг шаардсан хандлага байв. Гэтэл нөгөө талд буюу өрнөдөд Монгол нь Зөвлөлт лагерьт багтсан буюу Оросын дагуул улс мэт болсон учир улс төр, эдийн засаг, соёлын хувьд ихээхэн анхаарсан нь “монгол судлал” хэмээх ойлголтыг эрчимжүүлэх үүд болсон.

Үнэн хэрэгтээ Монголыг судлах нь “Оросд орох үүд”-ийг олох явдал байсан нь тодорхой. Энэ зорилгын үүднээс өрнө дахин болон АНУ-д томоохон их дээд сургуулиудад профессорын орон тоо гаргах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, семинарууд эхэлсэн. Энэ

бүгдийн үр дүнд нэгэн үе дорно дахины судлал, хятад судлалын хавсрага явсан “монголын судлал” бүрэн биеэ даан хөгжих болсон нь ХХ зууны 2 дугаар хагас гэж хэлж болно.

Бие дааж эрчимтэй хөгжиж, олон нэр хүндтэй эрдэмтэд, шилдэг бүтээлүүд гарч эхэлснээр Цагаан хэрмийн арын нүүдэлчдийн түүх нь Хан Үндэстний хавсрага судалгаа биш болохыгоо тодорхой харуулснаас гадна дан ганц “харь нүд”-ний монгол судлал биш болохыг Монголд хөгжсөн түүхийн судалгаа харуулсан юм.

1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн үндсэн нэг чиглэл нь түүх, түүүний хамааралтай эх сурвалж баримтыг судлах, эрж хайх, цуглуулах, судалгааны эргэлтэд оруулах явдал байсан. Аажимдаа энэ зорилгоо хэрэгжүүлсээр 1950-иад оноос монголд үндэсний мэргэжилтэй түүхч бэлтгэгдэж эхэлсэн. Тэд юуны өмнө өөрийн түүхийг харах “монгол нүд” буюу чиг хандлагыг буй болгохын төлөө хичээсэн юм. Гэтэл энэ үед түүхийн судалгаанд хамгийн хэцүү хүнд нөхцөл тулгарсан юм. Тэр нь өөрийн зарчмын гол садаа “изм” буюу үзэл суртлын хүлээс байлаа. Түүх нь зөвхөн үзэл суртлаас ангид байх ёстой гэсэн түүхэн зүйн зарчмыг даван туулахад нэн хэцүү байсан ч монголын түүхчид Монголын түүхийн судалгааны хана хэрмийг ямар боловч босгож чадсан юм. Үүнийг босгосны ач нь өнөөдөр миний ярьж буй монголын түүх судлал нь дэлхийн монголын судлал дахь байр суурь гэсэн лекцийг унших үндэс болж чаджээ. Мэдээж хэрэг “Монголын судлал” 1990-ээд оноос хойш тэрхүү “изм”-ээс бага боловч холдсон ч улс орон бүрийн судалгааны эрх ашиг, нөгөө талаас Монголын түүхчдийн хувьд өөрийн хандлага, судалгааны түвшин янз бүр л байна.

2. Олон Улсын Монгол Судлалын холбоо ба өнөөгийн нөхцөл

Анх 1987 онд Олон Улсын Монголч эрдэмтдийн 5 дугаар Их хурлаар олон улсын эрдэмтэн судлаачид, Монголын эрдэмтдийн хамтын оролцоотойгоор Олон Улсын Монгол Судлалын Холбоог байгуулж, Холбооны дүрмээ баталж, удирдлага, зохион байгуулалтыг хийснээр энэхүү байгууллага албан ёсоор байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлэх болсон. Тус Их хурлаар Олон улсын Монгол судлалын Холбоог байгуулахдаа 34 орны 228 эрдэмтэн судлаачид оролцож санал нэгтэй байгуулсан бөгөөд холбоо байгуулсан явдал нь **“Монгол судлалын талаар олон улсын хамтын ажиллагааны түүхэнд чухал үйл явдал болсон хэмээн цохон тэмдэглээд Монгол судлалын төрөл бүрийн салбарт дэлхий даяар чухал ололт гаргасан их хурал”** хэмээн 5 дугаар хурлын протоколд тэмдэглэсэн байна.

Тус Холбооны зорилго чиглэлийг шинэ байгуулагдсан дүрмэндээ тэмдэглэхдээ:

“Олон улсын Монгол судлалын холбоо бол Монголч эрдэмтэд, монгол судлалын төв, холбоонуудыг сайн дурын үндсэн дээр эвлэлдүүлсэн, засгийн газрын бус, шинжлэх ухааны болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллага мөн” хэмээн тодорхойлж холбоо нь “Монголын судлалыг хөхүүлэн дэмжих, эрхлэн гүйцэтгэх, монголын судлалын төвүүд болон монголч эрдэмтдийн эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх, дэлхийн янз бүрийн орны эрдэмтдийн харилцан ойлголцох, хамтран ажиллах явдлыг дэмжихийг эрмэлзэнэ” хэмээн зорилгыг заан өгсөн нь өнөөг хүртэл үндсэн чиглэл хэвээр байна.

Тус холбоог гэнэт тус хурлаар байгуулаагүй бөгөөд Монголын эрдэмтдийн чармайлт, дэлхийн олон улс орны монгол судлаачдын дэмжлэг оролцоотойгоор 30 гаруй жилийн турш Монгол судлалын асуудлыг Монгол улсад төвлөрүүлэх, хөгжүүлэх, дэмжиж хөхүүлэх ажлыг тасралтгүй явуулж ирсний үр дүн байсан юм. Анх 1959 оны Олон улсын хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар хурлаас хойш хэд хэдэн хурлыг зохион байгуулж, хурлыг зохион байгуулах Байнгын хороог байгуулж, идэвхтэй, тасралтгүй үйл ажиллагааг явуулж чадснаар сая 1987 онд Монгол Судлалын анхны олон улсын байгууллагыг Монгол улсад байгуулж чадсан байна. Тус байгууллагыг байгуулснаар дэлхийн улс орны соёлын өвөрмөц онцлогийг бүрэн дүүрэн харуулж, тэгснээрээ бүх улс орон, ард түмэн бие биенээ танин мэдэх уур амьсгал бүрдүүлж, улмаар нэг нэгнээ харилцан хүндэлж дэлхийн янз бүрийн соёл, иргэншил хоорондоо бүтээлч холбоо тогтооход орших бөгөөд Олон улсын Монгол судлалын холбоо ч тийм зорилго баримталж байна хэмээн ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Федерико Майороос ирүүлсэн мэндчилгээнд тэмдэглэсэн байдаг.

Монгол судлалыг хөгжүүлэх, Монгол судлалын үйл ажиллагааг нэгтгэн зангидах, удирдан зохион байгуулахад тухайн үеийн Монгол улсын төр засгийн зүгээс онцгой анхаарал тавьж, дэмжиж туслаж байсныг бас тэмдэглэх хэрэгтэй. Хэдийгээр хүйтэн дайн бүрэн арилаагүй хүнд хэцүү үзэл суртлын зөрчилдөөн байсан ч монгол судлалын асуудлаар Монголын төр өөрийн гэсэн байр суурьтай, монгол судлаач эрдэмтэд үзэл суртлын хана хэрэмийг нэвтлэн эрдмийн анд нөхөд болж, олон сайхан арга хэмжээ, эрдэм бүтээлийг туурвиж, монгол судлалын гол тулгуур байгууллага байгуулах бүхий л нөхцөл боломжийг буй болгож байсныг бид тухайн цаг үед харилцаж байсан эрдэмтдийн захидал, төр засгийн шийдвэр, тогтоолтой холбоотой баримт бичгүүдээс мэдэж болно. Ялангуяа

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

энэ ажлыг эрхлэн гүйцэтгэхэд тухайн үеийн Гадаад явдлын яам, ШУА онцгой үүрэг гүйцэтгэж байсан нь өнөөдөр хүртэл энэ байгууллага оршин байх үндэс суурь бат бэх тавигджээ гэж ойлгож болно. Мөн тухайн байгууллагыг толгойлж, удирдаж байсан Ерөнхийлөгч Оуэн Латимор, Шига Озава, нарийн бичгийн дарга Ш.Бира, Д.Төмөртоогоо нарын эрдэмтдийн олон улсын монгол судлалд олсон нэр хүнд, тасралтгүй идэвхтэй үйл ажиллагааны үр дүн байсан юм. Ялангуяа өнөөдөр 90 насны сүүдэр тохиож буй нэртэй эрдэмтэн академич Ш.Бира гуай тус холбооны үйл ажиллагааг тасралтгүй явуулах, боломж бүгдийг хайж, 1990-ээд оны хүнд бэрх үед ч Монгол судлалын холбооны үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлж, олон улсын хурлуудыг зохион байгуулж, олон улс болон монголын төр засгаас зохих дэмжлэгүүдийг авч, тогтвортой хэвлэн нийтлүүлэх мэдээлэлийн биллютен, монголика сэтгүүлүүдийг эрхлэн гаргаж ирсэнд гүнээ талархаж байна. Мэдээж энэ холбооны үйл ажиллагааг явуулахад монголын монгол судлаач эрдэмтэн мэргэд та бүхний хүчин чармайлт, дэмжлэг, хамтын ажиллагаа гол тулгуур нь байсан гэдэгт гүнээ итгэж байна. Монгол судлалыг хөгжүүлэхийн тулд олон ч шинэ ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байсан. “Дэлхийн монгол судлалын дээжис” цуврал, “Дэлхийн Монголч эрдэмтдийн лавлах”, “олон улсын Монгол судлалын ном зүй” зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Нэлээд олон бүтээлийг хэвлэн нийтлүүлж монголын эрдэмтэн судлаачдад хүргэх ажлыг ч зохион байгуулсан байна.

Олон Улсын Монгол судлалын Холбоо энэ 30 жилийн хугацаанд хэдийгээр төрийн бус байгууллага боловч шинжлэх ухаан, зохион байгуулалтын хувьд бэхжиж, олон орны Монгол судлалын монголч эрдэмтэд, байгууллагуудтай ажил хэрэгч харилцаа үүсгэж, тэдэнтэй хамтран ажиллах төрөл бүрийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, олон улсын болон үндэсний хэмжээний нэлээд арга хэмжээг зохион байгуулж ирсэн. Энэ хугацаанд гүйцэтгэсэн нийт 11 удаагийн хуралд давхардсан тоогоор 40 гаруй орны нийт 4000 гаруй эрдэмтэн судлаачдыг оролцуулан Монголын судлалын хэд хэдэн салбар чиглэлээр томоохон хурлыг хийж, Монгол судлалын мэдээлэлийн сэтгүүл 60 орчим дугаар, Монголика эрдэм шинжилгээний сэтгүүл 40 дугаарыг эрхлэн гаргажээ. Монголы судлалын чиглэлээр тогтвортой хэвлэгдэж буй цөөхөн сэтгүүлийн нэг болж чадсан байна.

Мөн тус холбооноос гадна дэлхийн Монгол судлалын томоохон төвүүдэд монгол судлалын холбоо, төвүүд байгуулагдаж, тус Олон улсын монгол судлалын Холбоотой нягт хамтын ажиллагаатай явж ирсэн байна. Тухайлбал, Японы Монгол судлалын холбоо,

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Хятадын Монгол судлалын холбоо, Оросын монголч судлаачдын холбоо, Тувагийн Монгол судлалын төв, Англи-Монголын нийгэмлэг, Америкийн Монголын нийгэмлэг, Рерихийн гэр музей, ОХУ-ын Дорно дахины хүрээлэн, Буриадын Монгол, ТҮвэд, Буддын судлалын хрээлэн, Кембриджийн Монгол ба Дотоод Азийн судалгааны төв, Унгарын Монголыа Төв Азийн тэнхим, Польшийн Варшавын Их сургуулийн монгол, түвэд судлалын тэнхим, Чехийн Прагийн Их сургуулийн Монгол, түвэд судлалын салбар, Францийн Сибирь ба Монголын судалгааны төв, Японы Токиогийн гадаад судлалын сургууль, Осакагийн гадаад судлалын сургууль, Осакагийн Угсаатны музей, ӨМИС, Бээжингийн Төвийн Үндэстний Их сургууль зэргийг дурдахад хангалттай.

Одоогоор дэлхийд Монголын болон монголын хамаатай чиглэлээр судалгаа хийдэг нийт 30 гаруй улсын 800-аад эрдэмтэн байна гэсэн тооцоо байна. Тэдгээр эрдэмтэд монголын нэн эртний цаг үеэс өнөөг хүртэл монголын түүх, археологи, хэл соёл, угсаатан зүй, нийгэм эдийн засгийн байдал, хүн судлал, гадаад бодлого, байгаль орчны чиглэлээр дийлэнх судалгааг явуулж байгаа бөгөөд Монгол судлалтай хамаатай жилдээ 30-40 ном бүтээл гарч байна гэсэн баримжаа тоо мэдэгдэж байна. Монгол судлалын хамаатай 10 гаруй тогтмол сэтгүүл нийтлэгдэж байгаагаас Кембриджийн Их сургуулийн “Дотоод Ази” сэтгүүл, Америкийн Индиана Их сургуулийн “Монголын судлал”, ӨМИС-ын “Монгол судлал”, Солонгосын Монгол судлал, Японы Монгол судлалын мэдээлэл, Германы Төв Азийн судалгаа, Чехийн Монгол судлал, Польшийн Дорно дахины судлал зэрэг нэр хүндтэй сэтгүүлүүдийг дурдаж болно. Мөн Монгол улсад Хэл зохиол судлал, Монголика, Түүхийн судлал, Угсаатны судлал, Түүх судлал зэрэг сэтгүүлүүд ч тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Харин өнгөрсөн жилээс хойш тус холбооны шинэ удирдлага, зохион байгуулалтын хувьд шинэчлэгдэн бид бүхэнд Монгол судлалын чиглэлээр илүү өргөн хүрээтэй, эрчимтэй ажиллахыг олон монгол судлаачид итгэж найдаж сонгосон юм. Бид бүхэн энэ нэг жилийн хугацаанд нэлээд ажлыг төлөвлөн ажилласан бөгөөд юуны өмнө бидний үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн төрийн байгууллага, салбарын яам, хувь хүмүүст гүн талархаж байна. Бид бүхэн юуны өмнө цахим мэдээлэлийг илүүтэй ашиглаж мэдээлэлээр монгол судлаачдын үйл ажиллагааг хангахыг зорьж шинээр mongolianstudies.gov.mn сайтыг нээж, FB-ын Монгол судлал хаяг нээж, тогтмол мэдээлэлээр хангахыг зорьж байгаа бөгөөд холбооны дотоод зохион байгуулалтын

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

асуудлыг цэгцэлж, архив, ном, мэдээлэлийн сангаа стандартын дагуу шинэчлэн, 5 жилд нэг удаа их хурал хийдэг бус жил бүр монголын судлалын тулгамдсан аль нэг асуудлаар томоохон хэмжээний олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байхаар тогтон энэ жил Монголын бурханы шашны асуудлыг сонгон, Бурхан багшийн айлдвар: ганжуурын судалгаа олон улсын хурлыг зохион байгуулсан, мөн бүсчилсэн олон улсын хурал, семинар зохион байгуулахыг зорьж Ази, Европын намар, хаврын их семинар зохион байгуулахаар тогтож Европын семинарыг монгол судлалын үүссэн голомт ОХУ-ын Санкт-Петербургийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнд 4 сард зохион байгуулж, намрын Азийн семинарыг одоо 11 сарын 3-5-нд Бээжин хотод Төвийн Үндэстний Их сургуультай хамтран сурвалж судлалын чиглэлээр олон улсын хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Бид бүхэн эдгээр хурлуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсвэл бүрэн санхүүжүүлэх ажлыг хийгээд байна. Монгол улсад Япон, Австралийн Үндэсний Их сургуулийн эрдэмтэдтэй хамтран 8 сарын 27-28-нд ХХ узууны Монголын түүх, соёл нэртэй олон улсын хурлыг зохион байгуулсан.

Мөн Монгол судлаачдыг Монгол улсад судалгаа хийх боломжоор хангах, хамтын судалгаа явуулах, хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор хэд хэдэн ажлыг эхлүүлсэн байна. Тухайлбал, Оросын залуу хоёр судлаач, БНХАУ-ын 1 судлаачыг тэтгэлэг олгож, Монгол улсад судалгааны ажил хийлгэсэн. Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн сан хөмрөгийн бүртгэлийг шинэчлэх ажлыг зохион байгуулахад оролцуулав. Монгол судлалын олон улсын холбооны удирдлага, ялангуяа дэд ерөнхийлөгч нарын маш идэвхтэй үйл ажиллагаа энэ хугацаанд идэвхтэй байсныг дурдах хүсэлтэй байна. Монгол судлалын холбооны дэд Ерөнхийлөгч, Кембрижийн Их сургуулийн профессор Урадын Булагын оролцоо, дэмжлэг, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэмжлэгээр “Европд тархсан монгол өв соёл” төслийг хэрэгжүүлж, Европын олон орны судлагааны газар, музей, номын сангуудад байгаа монголын хамаатай өв соёлын бүртгэл, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хамтран ном бүтээл туурвих эхний шатны ажлуудыг амжилттай хийгээд байна. Үүний хүрээнд Эрмитаж дахь Ноён уулын бүрэн цуглуулгаар каталоги гаргаад байгааг та бүхэн мэднэ. Мөн Япон улсын Хүмүүнлэгийн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал, Монгол судлалын Холбооны дэд Ерөнхийлөгч Юки Коанагаягийн дэмжлэгээр дэлхийн улс орнуудад тархсан монголын тухай хуучин гэрэл зургийн нэгдсэн мэдээлэлийн санг байгуулах төсөл эхлээд байна. Ерөнхийлөгчийн ивээл

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

дор хийсэн монгол толь нэгдсэн сайт, монгол хэлний толь, монголын археологийн нэгдсэн мэдээлэлийн сан, түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн цахим нэгдсэн сан зэргийг холбооны мэдээлэлийн санд оруулах талаар зорилго тавиад байна. Өөрөөр хэлбэл, удахгүй Манай Холбооны сайдаас монголын тухай хуучин гэрэл зургийн нэгдсэн сан хөмрөгийг үзэж танилцах ашиглах бүрэн боломж буй болно. Ер нь цаашдаа Монгол судлалын холбоо нь мэдээллийн цахим ертөнцийг бүрэн хангасан, цахим мэдээлэлийн сангуудыг буй болгосон шуурхай, мэдээлэл сайтай төв байх зорилготой.

Бид бүхэн энэ жилээс “монгол судлалын сонгодог бүтээл” цуврал эхлүүлээд байна. Одоогоор Унгарын нэртэй монгол судлаач Алиса Саркозийгийн олон жилийн бүтээл Суматраднагийн толь номыг хэвлэн нийтлүүлэхэд бэлэн болжээ. Мөн дөнгөж саяхан БСШУС-ын яамны дэмжлэгээр Ш.Бира академичийн эрдэмийн бүтээлийн эмхэтгэл 10 боть номыг хэвлэлээс аваад байна. Нөгөөдөр та бүхэнд шинэ номын нээлтээр хүрнэ гэдэгт итгэж байна. Олон улсын Монгол судлалын байгууллагууд, төв, эрдэмтдийн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, ном бүтээл, хурал зөвлөгөөн ч монгол судлалыг хөгжүүлэхэд өөр өөрийн зүгээс үзүүлж байгаа томоохон хувь нэмэр гэж үзэж байна. Манай Холбооны зүгээс цаашид жил бүр шилдэг монгол судлаач хэмээх монгол судлалд гарамгай амжилт гаргасан нэг эрдэмтэнд томоохон хэмжээний шагнал, цомыг олгох, холбооны нэрэмжит тэтгэлэг залуу судлаачдад олгох, монголын монгол судлаачдын бүтээл, олон улсын түвшинд нийтлэгдсэн бүтээлүүдийг сурталчлах, монголын өв соёлын чиглэлийн судалгааны ажлуудын үр дүнг сурталчлах, монгол улсад судалгаа хийх боломжоор хангах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээс гадна Монгол судлалын хүрээ хязгаараа тодорхойлох, урт богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөгөө эрдэмтэн судлаачид, холбооны удирдлагын түвшинд хэлэлцэж батлах, холбооны санхүүжилтийн асуудлыг тогтвортой болгох, гишүүнчлэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, алсын зорилготооо монгол судлалын өөрийн байр савтай болох хүртэл зорилт тавин ажиллаж байна.

Монголын судлалыг энэ мэтээр цаашид хөгжүүлэх, өргөжүүлэх талаар та бидэнд хийх зүйл асар их, бас өндөр хариуцлага байна. Хэдийгээр монголын төрөөс сүүлийн жилүүдэд анхаарч, эрх зүйн хамаатай хэд хэдэн баримт бичгүүдийг гаргаж, дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа ч тус холбооны талаар тодорхой, тогтвортой байр суурьтай байр шаардлагатай байна. Энэ холбоо хэдийгээр олон улсын байгууллагуудын гишүүнчлэлтэй төрийн бус байгууллага боловч Монгол судлалын гол төв, Монголын Үндэсний Аюулгүй

байдлын хуульд тусгай заалттай, дэлхийн Монгол судлалын төвийг монголд байлгахад гол үүрэг гүйцтгэж байгаа стратегийн ач холбогдолтой байгууллага гэдгийг онцгой анхаарах шаардлагатай байна. Энэ байгууллага нь дэлхийн монгол судлалыг мэдээлэлээр хангах, нэгдсэн удирдлагатай байлгах, судлаачдад судалгааны ажиллах боломж олгох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, монголыг дэлхий дахинд сурталчлах зэрэг үндсэн үүрэг бүхий газар болно. Тиймээс бид бүхэн өнөөдрийг хүртэл төрөөс санхүүгийн дэмжлэг тогтвортой бус авдаг, өөрөөр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар явж ирсэн нь холбооны үйл ажиллагааг тогтвортой бус явагдахад хүргэсэн одоо ч энэ байдал хэвээр байгаа юм. Хэрвээ Монгол улсын төрөөс Монгол судлалыг дэмжих, монгол судлалыг монголын том эрх ашиг, дэлхий дахинтай харилцах гол үүд гэж анхаарч байгаа бол энэ Холбооны үйл ажиллагааг байнга анхаарах, бид ч мөн хичээн ажиллах тал, талын үүрэг хариуцлага байгаа гэдгийг та бид сайтар ухамсарлаж ойлгоно байхаа. Монгол орон, монголын түүх, монгол хэл, монгол нутаг бол дэлхий дахины анхаарал, судалгааны нэгэн том ай сав байсаар ирсэн цаашид улам илүү их анхаарч судлагдах бүрэн боломжтой гайхамшигт нутаг орон билээ. Энэ сайхан орныг минь судлан шинжлэх, танин мэдэх хүн төрөлхтөний оюун санааны том орон зай болсон монголын судлал хэмээх шинжлэх ухааны нэгэн томоохон чиглэлийг монголын эрдэмтэн судлаачид та бид хамтдаа хөгжүүлж, тээж авч явах бөгөөд бидний хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, эв нэгдэл ямагт тэргүүн эгнээнд байж чадах ба монголын судлалыг цэцэглэн хөгжүүлэхийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлтэй, өөрөө өөрийгөө даван туулсан

3. Дэлхийн монголын судлал дахь түүх судлалын үндсэн чиглэлүүд ба онцлог.

Өнөөдөр дэлхийн Монголын судлалд монголын түүхийн судалгаа дараахь хэдэн онцлогтой явагдаж байна. үүнд:

1. Монголын түүхийн судалгааны хүрээ хязгаар түүнийг эргэн харах
2. Түүхийн судалгааны баялаг сан хөмрөгүүдийг шинээр нээх, судалгааны эргэлтэд оруулах
3. Монголын түүх ба дэлхий дахины харилцаа
4. Судлагааны чиглэлүүдийн интеграциуд ба асуудал

Үндсэндээ ийм хэдэн асуудал дээр төвлөрч Монголын түүхийн судалгаа явагдаж байна гэж тоймлон харж болно. Юуны өмнө 1-р асуудал.

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Монголын түүхийг судлахын тулд эхлээд хил хязгаар, хүрээ хэмжээг харах явдал өнөөдөр дахин дэвшигдэж байна. ХХ зууны 2-р хагаст Монголын судлал нь их төлөв “монгол улс” гэсэн төвлөрөл дээр явагдаж байсан нь нэг талаасаа цэвэр улс төрийн агуулгатай байсан юм. Гэтэл эдүгээ монгол судлалын хувьд ч тэр манай түүхчдийн судалгаанд ч тэр Монголын түүхийн хязгаарыг тогтоох явдал нь дахин системтэй харах боломж, бас орчин үеийн шаардлагыг хангана. Ийм хандлагыг 1980-аад оны эцсээс гадны судлаачид нэлээд оролдсоор байна. Мэдээж улс бүрийн авч үзэх хандлага нь өөр байна.

- Англи, АНУ зэрэгт “Дотоод Ази ба Монгол”
- Францууд “Сибирь ба Монгол”
- Оросууд “Төв Ази ба монгол”
- Япон, Солонгосууд “Монгол ба зүүн хойд Ази”, “Монгол ба Евроази”
- Хятадууд “умардууд ба нүүдэлчин монголчууд”

гэх зэргээр тодорхой бүс нутгийн хүрээнд Монголыг уялдуулан авч үзэж байна. Өөрөөр хэлбэл Монголын түүх-соёлыг судлахдаа тодорхой бүс нутгийн төв болгож харах явдал илүүтэй болж байна. дээрх чиглэлээрээ тухайн улсууд Монгол судлалын төвүүд, судалгааны семинариуд, төсөл хөтөлбөрөө нэрлэж байна. Үүний гол шалтгаан нь Монгол улс төвтэй юм уу эсвэл монголчууд төвтэй юм уу гэдгийг ойлгох хэрэгтэй. Ерөнхийдөө 1990-ээд оноос хойш пост коммунист үеийн хандлага нь монгол “улс”-аас монгол “хүн” гэдэг ойлголт руу чиглэгдэж эхэлсэн. Соёл, уламжлал, амьдралын хэв маяг, хэл, ахуйн ижилсэл, угсаа гаралын чиглэлийг илүүтэй авч үзэж “Монгол соёлын ай сав” гэж харах болсон. Энэ нь бидний түүхийг гадныхан зааглаж буй хандлага. Харин бид уг асуудлыг яаж авч үзэж байна бэ? гэдэг чухлаар тавигдана.

Монгол улсын хувьд 1990-ээд оноос түүх бичлэгийн болон түүхээ авч үзэх нэгэн шинэ үе эхэлсэн гэж ойлгож болно. 50 орчим жил “марксист” онолыг үндсэн чиглэл болгож хөгжиж ирсэн түүхийн судалгаа нэг л өдөр өөрийн онол арга зүйн чиглэл, прадиigma байхгүй болчихсон. Ингэснээр түүхчид шинэ чиглэл хандлагад орох шаардлага буй болсон. Гэвч оролдлого бараг хийгээгүй. Онолын томоохон маргаанууд, хэлэлцүүлэг, төсөөлөлүүдийн талаар ч бодитой зүйлс бараг нийтлэгдээгүй нь уг судалгааны чиглэлийг үзэл баримтлалгүй “бусдыг дуурайх”, “хэт өөриймсөглөх”, “үндэсний үзэл”, “жалга судар”, “танил тал”-ын түүх бичлэг гаарахад хүргэчихсэн юм. Монголын түүхийн судалгааны хил хязгаар, хандлага, гадны судалгааны онол арга зүйн чиглэлтэй уяж өгөх

явдал бараг үгүй байлаа гэсэн үг. Тийм ч учраас өнөөдөр маргаан үүсгээд байгаа монголын түүх судлалын хүрээ хязгаарыг тогтоох, бүс нутгийн онцлогтой уялдуулах асуудлын талаар харьцангуй бага төсөөлөл оршсоор байна.

Сүүлийн хэдэн жилд хүссэн ч эс хүссэн ч энэ чиглэлд анхаарах, өөрийн судалгааны “нүд”-ээ нээх, онол арга зүйн чиглэлээ зөв тогтоохын төлөө хичээх болсон ч бодитой үр дүн мэдээж цаг хугацаанаас хамаарахаар байна. Монголын түүхийн судалгааг “улс”-аас “бүс нутаг” руу оруулах, түүний ай савд хамаатуулан судлах явдал эхлэхийг хичээж байна. Гэхдээ өрнө дахины болон дорно дахины дээрх улс орнуудын аль нэгийг дагах уу эсвэл монголын түүхчид өөрийн чиглэлийг хөндөж тавих уу гэдэг нь нэлээд асуудал юм. Юутай ч Монголын түүхийг “Монгол улс”-ын 1915 онд тогтоосон Хиагтын гэрээний хилээр харах боломжгүй “Монголын ертөнц”, “монгол туургатан”, “монголчууд” гэсэн нэрийтгэлийн доор өргөн хүрээнд авч үзэх нь тодорхой болоод байх шиг байна.

Харин бүс нутгийн заагийг яаж тогтоох бэе гэдэг эргэлзээтэй. Умардад Сибирь, алс дорнод, Солонгосын хойг, Өмнө зүгт Их цагаан хэрэм, Түвэдийн өндөрлөг, Тэнгэр уулын ар зах, Казахстаны уудам тал нутаг буюу Евразийн тал нутгаар заагласан Монгол ба түүний бүс нутаг гэсэн өргөн хүрээ тогтох юм. Энэ бүс нутгийг монгол төвтэй гэх үү эсвэл Монгол улс төвтэй гэх үү гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. Монгол төвтэй гэвэл энэ бүс нутгийн түүхэнд соёл, уламжлал, ахуй байдлын ямар нөлөөг бид үзүүлж чадсан, Монгол улс төвтэй гэвэл “*Монголын эзэнт*” улсыг санагалзсан мэт харагдах гээд хүндхэн асуудал тулгараад байгааг анзаарах хэрэгтэй. Асуудлыг дэлхийн чиг хандлагатай дүйлгэх, онол арга зүйн чигийг тогтоох, Монголын түүхчдийн судалгааг илүү өргөн хүрээнд авч үзэхийн тулд бид “Монголчууд” төвтэй бүс нутаг гэсэн ойлголтыг гаргаж тавих нь зөв ч байж мэднэ. Монголчууд сүүлийн 2000 мянган жилд энэ бүс нутагт том үүргийг гүйцэтгэж чадснаас гадна эзлэн орших газар нутаг, соёл-ахуйн өвөрмөц оршин байх хэлбэрийн сонгодог жишээ болж чадаж байгаа зэргийг харгалзан үзэх боломжтой. Зарим судлаачдаас үүнийг Монгол улс хэмээх төвийг саармагжуулах, хэт өргөн хүрээтэй болгох, империйн хандлагатай гэж шүүмжлэх явдал үзэгдэж мэднэ. Тэгвэл үүнд соёл, түүхийн үндэслэл байхаас өнөөгийн улс төрийн агуулга байхгүйг бас саначих хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл Монголын түүх-соёлыг судлаж буй бид өнөөгийн тогтоосон саяхны хил заагаар олон зуун жилийн түүх соёлын улбаа, харилцан хамаарлыг хэрчин хувааж, “бүс нутаг”-аас “орон нутаг” судлалын хэмжээнд авч үзээд байгаагаараа алдаа гаргаад,

өрнө, дорнын судалгааны түвшингээс хол орхигдоод байгаа биш үү гэсэн асуудал үүсээд байгааг соёлын судалгааг хийж буй та нарт ч хамаатай буй за.

Мэдээж энэ чиглэлээр сүүлийн үед олон бүтээл дэлхийн эрдэмтэд туурвиж байна. Тухайлбал, АНУ-ын эрдэмтэн Никола де Косма, Хазанов, Томас Барфильд, Петер Голден, Английн Дэвид Снийт, К.Хамфри, У.Булаг, Оросын Н.Крадин, Т.Д.Скрынникова, Японы Окада Хидохиро, Ока Хироки, Солнгосын Ким Хо дун, Хятадын Чимэддорж, Чэн Чүн Дэ зэрэг эрдэмтдийн бүтээлээс тодорхой харагдана.

5. Түүхийн судалгааны баялаг сан хөмрөгүүдийг шинээр нээх, судалгааны эргэлтэд оруулах

Өнөөдөр дэлхийн Монгол судлалын дотор төдийгүй манай түүхийн судалгаанд Монголчуудын түүхийн судалгааны эх баримтууд, эд өлгийн зүйлс шинээр илэрч олох, өмнө олдсон зүйлсийг дахин судалгааны эргэлтэд оруулах талаар нэг бүхэл бүтэн давалгаа явагдаж байгааг та бүхэн сайн мэднэ. Түүхийн судалгааны онол арга зүйн түвшингээс гадна түүний гол объект эх сурвалж баримт гэдэг үнэлэх аргагүй чухал гэдэг нь ойлгомжтой. Хоёр чиглэл давамгайлж байна. хувийн жижиггар бичмэлээс томоохон түүхийн зохиолуудыг хүртэл нээж олж, түүх-соёлын олон сайхан дурсгалууд илрээд байна. Тэдгээр нь Монголчуудын түүхийг дахин шинээр харах, онол арга зүйн хувьд урагш ахих, ямар нэгэн үзэл суртал, нөлөөлөлгүй судлах боломж өрнөж байгаад оршино. Түүхийн арга зүйн хувьд эх баримтыг судалгааны эргэлтэд оруулахдаа текстологи, герменевтикийн судалгааг хийх явдал Монголын судлалд бас эрчимжиж байна.

Монголын түүхийн эх сурвалжууд нь урд өмнө англи, орос заримдаа цөөн эрдэмтэд хятад хэлнээс дамжуулан судалдаг байсан бол эдүгээ монголын түүхийн бүх эх сурвалжийг эх материалаас уншиж чадах, перс, араб, түвд, манж, хуучин орос, солонгос, хятад, армен, латин хэлний сурвалж унших мэргэжилтнүүд монголд бүрэлдэж чаджээ. Үүнээс үзвэл Монголын түүхийн судалгаа нь эх сурвалжаасаа хамааран мөн л бүс нутгийн хамааралд хамгийн их уялдаж байгаа юм. Бид монголчуудын эргэн тойрон буй бүс нутгийн ихэнх ард түмний хэл дээрх баримтуудаас өөрийн түүхийг мэдээлэлийг авч ажиллаж байна.

Боловсон хүчнийг энэ чиглэл дээр илүүтэй бэлтгэж чадвал бид түүх судлалын хувьд онол арга зүйн хувьд өрнө, дорнын монгол судлалтай ойртон очиж, монголын эрдэмтэд лаборториос тэгш эрхтэй судлаач руу шилжих боломж ойрхон байгаа.

Нөгөө талаар монголын түүх судлалыг хөгжүүлэхэд Монголын архив, номын сан, археологи, угсаатны хээрийн судалгаанууд ихээхэн чухалтай бөгөөд үүнийг судалгааны эргэлтэд оруулах, судлах боломж, эрх зүйн чөдөр тушааг арилгах хэрэгтэй. Монгол шиг ийм орчин үеийн шаардлагад нийцээгүй, түүнийг сөрсөн архив номын сантай улс дэлхийд одоохондоо үгүй байгаа нь Монголын түүх судлалыг хөгжүүлэхэд ихээхэн саад төдийгүй монгол судлаачдыг өөр улсад хуйларах үүд болж байна.

Монголын түүхчид харь улсуудын номын сан, музей, архиваас чөлөөтэй судалгаа хийх эрхтэй, олон сайхан бүтээлүүдийг олж байгаа ч гэсэн монгол улс өөрөө Монголын түүх судлалын хамгийн том голомт, сан хөмрөг гэдгийг хэн ч үгүйсгэхгүй. Түүх, угсаатны зүй, соёл судлал, археологийн олдворуудыг хамтран судлах боломж бүрэн байгаа ч судалгааны чиглэл хандлага тодорхой биш байгаатай холбоотой энэ асуудал үргэлж хувь судлаачийн хэмжээнд эсвэл огт хамтрахгүй байх гэдгээр тодорхойлогдож байдаг. Өнөөдөр Монгол улсад Монголын соёл түүхийн нэгдсэн мэдээлэлийн сан, түүнийг чөлөөтэй ашиглах боломж бараг үгүй байгаа нь биднийг 1990-ээд оноос өмнөх хаалттай нийгмээс гарсан гэж хэлэхэд улам хэцүү байдалд оруулж байгаа нь бодит байдал. Үүнийг судлаачид, түүхчид өөрсдөө гаргаж тодорхойлох, арга зүйг нь зааж өгөх, судалгааны эргэлтэд оруулах явдал нэн чухлаар тавигдаж буйг монголын түүхчид ч гадны монгол судлаачид ч санал нэгтэй байна.

Өөрөөр хэлбэл Монгол нь түүх судлалын хувьд хэн ч судалгаа хийж болох тийм чөлөөт талбар, судалгааны нөхцөлт газар байж чадвал дэлхийн Монгол судлалын түүхийн судалгааны голомт хэвээр удаан оршин тогтнох боломжтой.

4. Монголын түүх ба дэлхий дахины харилцаа

Монголын түүхийн судалгааны түвшин, түүний бодит нөхцөл нь дэлхийн Монгол судлалын дотор хэдийгээр тодорхой шат ахиж байгаа ч гэсэн хэд хэдэн шалтгаанаар өнөөг хүртэл амжилттай явагдаж чадахгүй байна. Үүний шалтгаан нь бусад салбар шинжлэх ухаануудад ч хамаатай байж мэднэ. Бидний байнга тоочдог хэлний бэрхшээл бол үүний шалтгаан ерөөсөө биш. Бидний хамгийн том шалтгаан бол түүхийн судалгааны онол арга зүй, прагматик хомсдол. Түүхийг судлах хүрээ хязгаар, түүний гол объект эх сурвалжтай ажиллах чадвар, бэлтгэж буй боловсон хүчин, хөтөлбөрийн доголдол үүнд хамаатай. Энэ бүгд дутуугаас гадна түүхчийн ёс зүйн асуудал хамгийн чухал тооцогдоно.

Угаасаа социалист магадгүй түүнээс өмнөх үеэс эхлэн түүхч хүнийг хамгийн “эх оронч” хүнээр шалгаруулчихсан. Түүндээ хүн бүр итгэдэгээс гадна түүхчид өөрсдөө итгэдэг болсон нь нэг шалтгаан мөн. Түүхч хүн бол үнэн хэрэгтээ үндэсний үзэл, мухар сүсэг, нам эсвлийн гишүүн, ямар нэгэн үзэл суртлын асуудлаас өөрийгөө бүрэн чөлөөлсөн байх ёстой байдаг. Гэтэл манайд мэргэжлийн түүхчид нь ийм зүйлд өртөх нь хэт их байгаа учир судлаж буй судалгаа мөн тэр хирээр субектив хандлагын халдлагад өртдөг. Халдлагад өртсөн судалгааг дэлхий дахинд хэзээ ч уншихгүй. Түүх бол өөрөө уран зохиол эсвэл домог үлгэр биш. Энэ нь түүнийг шинжлэх ухаан гэдгийг хэлж байгаа юм.

Түүхийн судалгааг хийсэн байдлыг харвал 1990-ээд оноос хойш “орон нутаг судлал”, “намтар судлал”, “магтаал”, “хагас уран зохиол”, “өөрийн сэтгэглдэл”, “онол арга зүйн мэдэмхийрсэн таамаглал”, “үндэсний болон үндэсрхэх үзэл” ноёлсон судалгаа давамгайлж байна. Тэдний шалтгаан нь Монголын түүхчид судалгааны онол арга зүйн чиглэл, хүрээ хязгаар, эх сурвалжаа нотлон баримтлах явдалд алдаа гаргаснаа тооцож үзэх хэрэгтэй. Бид ч энэ алдааг арилгахыг хичээж байгаа ч цаг хугацаа хэрэгтэй юм байна. Агуулгаар нь тодорхойлбол түүхчид төдийгүй нийгмийн ухааны салбарынхан ёс зүй, онол арга зүйн мэдлэгээ төлөвшүүлээгүй, асуудлыг шинжлэх ухаанчаар бус сэтгэл хөдлөл, нөлөөлөл, үзэл суртлаар харах явдал тогтсон хандлага стеротип болчихсонтой холбоотой.

Түүхийн судалгаанд “*историзм*” буюу түүхэн зүйн зарчмыг хатуу баримталдаг, үндэсний үзэл санаа, эх оронч гэсэн зохиол нэрийтгэлүүдээс өөрийгөө чөлөөлсөн, түүх бичлэгийн хэв маяг тогтоож чадвал бид Монголын судлалд нэгэн шинэ төрхийг буй болгож чадна. Монголын нийгмийн ухааны салбарууд үүнд дүгнэлт хийж, хэлэлцүүлэг хийж, санал солилцож, орчин үеийн монгол судлалын талбарын нөхцлөө зөв тодорхойлохыг цаг хугацаа, өнөөдөр дэлхий дахинд хийгдэж буй судалгаанууд шаардаж байна.

6. Судлагааны чиглэлүүдийн интеграциуд ба асуудал

Судалгааны өнөөгийн нөхцөл нь биднийг хамтрахыг шаардаж байна. Соёл судлал, урлагийн бүхий л төрлийг судалгааг олон улсын чанартай байлгах, түүнд дөхүүлэхийг хүсвэл нийгмийн ухааны салбарууд төдийгүй бусад байгалийн шинжлэлийн салбаруудтай ч гэсэн нэгдэж, хамтран судалгаа явуулах нь зүйтэйг олон улсын монгол судлалын хандлага харуулж байна. жишээлбэл нийгэм-соёлын хүн судлалын салбар дахь бөөгийн

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

мөргөл, монголчуудын далдын ид идийн талаарх судалгааг био орон зайн судалгаа, археологи геофизик, угсаатны судлал технологийн судалгаатай гэх мэтээр уялдаж байна.

Монгол судлалын цаашдын хандлага, боломж

- Дэлхийн олон улс оронд тархсан монгол үндэстний бичиг соёлын өв уламжлалыг бүртгэн судлах, монгол судлалын шинэ залуу үеийг бэлтгэх, гадаадын монгол судлалын төвүүдэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх, монгол судлалын чиглэлээр томоохон бүтээл туурвисан эрдэмтдэд урамшуулал олгох, монгол судлалын мэдээллийг тогтмол, шуурхай түгээх, тодорхой чухал сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулах ажлыг тогтмолжуулах
- Дэлхийн монгол судлалын эрдэмтэн судлаачдын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл шинээр туурвих, монгол судлаачдыг Монгол улсад ажиллахад тухайн орны нөхцөлөөс дордуулахгүй байдлаар цалинжуулах
- Урьд өмнө хэвлэн нийтлэгдээгүй шинэ баримт мэдээллийг хэвлэн нийтлүүлэх, монгол судлаач эрдэмтэдтэй хамтран ажиллах, судалгааны цар хүрээг өргөтгөх
- Монгол улсын судлаачдын хандлага байр суурийг өөрчлөх, ухвар мөчид хандлагыг арилгах, 1990-ээд оноос өмнөх байдлаас ахисан түвшинд оруулах
- Дэлхийн монгол судлалын хил хязгаарыг тодорхой болгож, бүс нутгийн судалгаануудтай уялдуулан судлах, боловсон хүчнээ энэ хүрээнд боловсруулах цогц бодлого шаардлагатай.
- Олон улсын судалгааны чиг хандлагад нийцүүлэн судалгааны хэрэгцээ, тэргүүлэх чиглэлээ тогтоох, шинжлэх ухааны тодорхой чиглэлээр буй болгосон үр дүнг янз бүрийн соёлын хүрээнд хуримтлагдсан уламжлалт мэдлэг,орчин үеийн дэвшилтэд технологийн үр дүнтэй хослуулан судлах
- Дэлхийн өөр улс орнуудын судлалын шинжлэх ухаанд гарсан тодорхой дэвшлүүдийг монгол судлалын хөгжилд хэрхэн авч ашиглах талаар нэгдмэл бодлоготой байх
- Урт богино хугацааны ирээдүйн талаарх монгол судлалын үнэлгээ, таамаглалыг улам бүр боловсронгуй болгож, 5 жил тутам зохион байгуулагдаж буй хурлаар тусгай салбар болгон хэлэлцүүлдэг болох

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

- Монгол судлалыг хөгжүүлэх зорилтыг хангахад улс орон бүрийн оролцоог буй болгохыг зорих ч уламжлалт, тодорхой хүний нөөц, улс төр, эдийн засгийн сонирхол бүхий улсуудад түлхүү анхаарах замаар үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх
- Хамгийн үр ашигтай тогтвортой мэдлэгийг буй болгох сүлжээний нээлттэй платформыг буй болгох, үр дүнгүй хэрэгжсэн эсэх нь мэдэгдэхгүй төслүүд биш тодорхой үр дүнтэй хамтын ажиллагааг чухалчлан түүний үр дүнгээр төрөөс дэмжлэг үзүүлдэг болгох
- “Монгол судлалын ордон” эсвэл томоохон цогц төвтэй болох

ХАВСРАЛТ 2.

Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний бодлого хэлэлцүүлэг, УБ, 2022.03.10.



Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал

ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Олон Улсын Монгол Судлалын Холбооны түүхэн замнал

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун



- 1959 онд эхэлсэн Хэл бичгийн Эрдэмтдийн анхдугаар Их хурлаас эх сууриа тавьсан.
- 1970 онд ШУА-ийн дэргэд Монголч Эрдэмтдийн Байнгын Хороог байгуулж академич Б.Ширэндэв удирдсан.
- 1987 онд 36 орон, олон улсын 4 байгууллага, ЮНЕСКО-гийн Ерөнхий нарийн бичгийн даргын бие төлөөлөгчийн оролцоотойгоор "Олон Улсын Монгол Судлалын Холбоо"-г байгуулах шийдвэр гаргасан.
- БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 107 дугаар тогтоолоор ОУМСХ-ны нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулж О.Латимор ерөнхийлөгчөөр, академич Ш.Бира ЕНБД-аар ажилласан.
- ОУМСХ нь 2020 оны 10 сард ЮНЕСКО-гийн гишүүн төрийн бус байгууллагын статустай болж өргөжсөн
- Ашгийн төлөө бус төрийн бус байгууллага болно.

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Бүтэц бүрэлдэхүүн



- Ерөнхийлөгч Унгар Улсын Элта Их сургуулийн профессор Агнеш Бирталан
- Хүндэт Ерөнхийлөгчид
- Дэд ерөнхийлөгчид
- Ерөнхий нарийн бичгийн дарга
- Зөвлөлдөх товчоон гишүүд
- Хүндэт гишүүд
- Нийт 62 хүний бүрэлдэхүүнтэй Холбооны байнгын хороо ажилладаг.
- Одоогоор 2019 оны байдлаар нийт 27 орны 614 гишүүнтэй. Үүнээс 446 нь гадаад улс орны, 168 нь дотоодын судлаачид болно.
- Албан ёсны вэб хуудас <http://iams.org.mn/> болно.

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
акадегич С.Чулуун

Холбооны үндсэн зорилго

- ▶ Олон улсын монгол судлалыг хөхиүлэн дэмжих
- ▶ Монгол судлалын талаарх төр засгийн бодлого шийдвэртэй уялдуулан эрдэм шинжилгээний ажлыг эрхлэн явуулахад дэмжлэг үзүүлэх
- ▶ Дэлхийн монгол судлаачдыг монгол судлалын холбоотой мэдээллээр хангах
- ▶ Олон орны эрдэмтдийн харилцан ойлголцол, хамтран ажиллах явдлыг дэмжих
- ▶ Ахмад, залуу үеийн эрдэмтэн судлаачдын эрдэм судлалын үйл ажиллагаанд нэмэр үзүүлэх
- ▶ Олон Улсын монголч эрдэмтдийн Их хурлыг удирдан зохион байгуулах



Холбооны үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн баримт бичгүүд

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
акадегич С.Чулуун

"Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6, 3.1.4-т "... үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх, судлах ажлыг дэмжих"; 3.1.4.1 Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншилыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, **Дэлхийн Монгол судлалын төвийг Улаанбаатарт байгуулж** монголч эрдэмтдийг судалгааны ажлуудад татан оролцуулах, бусад оронд салбар байгуулах ажлыг зохион байгуулах,

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хипийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагааг төлөвшинө.

2. "Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 3.1-д "... улс орны хөгжилд чухал ач холбогдол бүхий шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэх";

3. "Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-ний 3.4.V-д "... монголчуудын эх хэл, түүх, соёл иргэншил, утга зохиол, урлаг, гүн ухаан, угсаа гарал, зан заншил, уламжлал, зан үйл, аж төрөх хэв маягийн судалгаа нь нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэргүүлэх чиглэл байх болно "; о

4. "Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 3.4.3-т "... монгол үндэстний гарал үүсэл, түүх соёлыг дэлхий дахинд сурталчлах, үнэн зөв мэдээлэл өгөх"; 3.2.1. Монголч эрдэмтдийн хамтын ажиллагааг дэмжин нэгтгэн зохицуулах, мэдээллээр хангах, монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий байгууллагын тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих; 3.4.3. Монгол судлалын мэдээллийн цахим сан бүрдүүлж, тогтмол баяжуулж, мэдээлэх;

Олон улсын Монголч эрдэмтэдийн Их хурал

- ▶ ОУМЭ-ий I их хурал. Улаанбаатар, 1959 оны 9.1-8
- ▶ ОУМЭ-ий II их хурал. Улаанбаатар, 1970 оны 9. 2-7
- ▶ ОУМЭ-ий III их хурал. Улаанбаатар, 1976 оны 8.30-9.3
- ▶ ОУМЭ-ий IV их хурал. Улаанбаатар, 1982 оны 8. 24-28
- ▶ ОУМЭ-ий V их хурал. Улаанбаатар, 1987 оны 9.14-20
- ▶ ОУМЭ-ий VI их хурал. Улаанбаатар, 1992 оны 8. 11-15
- ▶ ОУМЭ-ий VII их хурал. Улаанбаатар, 1997 оны 8. 12-16
- ▶ ОУМЭ-ий VIII их хурал. Улаанбаатар, 2002 оны 8. 5-11
- ▶ ОУМЭ-ий IX их хурал. Улаанбаатар, 2006 оны 8. 8-12
- ▶ ОУМЭ-ий X их хурал. Улаанбаатар, 2011 оны 8. 9-13
- ▶ ОУМЭ-ий XI их хурал. Улаанбаатар, 2016 оны 8.15-18
- ▶ ОУМЭ-ий XII их хурал. Улаанбаатар-Хархорин, 2022 оны 8.05-12

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

2016-2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлын товч тойм (Олон улсын бүсийн хурал)

- ОУМСХ-ноос анх удаагаа санаачилан Ази, Европын бүсийн хурлыг зохион байгуулсан **7** удаа зохион байгуулсан.
- Үндэсний хэмжээний олон улсын хурлыг зохион байгуулсан **6** хурал зохион байгуулсан.
- Тодорхой байгууллага, хувь хүмүүстэй хамтран түүх, археологи, угсаатны судлал, хэл шинжлэл, аман зохиол, соёл судлалын чиглэлээр нийт **14** удаагийн хурал хамтран зохион байгуулсан.
- Ковидын бус нөхцөл байдалтай 3 жилийн хугацаанд **28** олон улсын болон орон нутгийн чанартай хуралд давхардсан тоогоор нийт **770** гаруй дотоод, гадаадын монгол судлаачид оролцсон байна.

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун



ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Бүсийн хурлын зардлын байдлыг тоймлон харвал:


- ▶ 2017 оны Санкт-Петербургийн архивын баримт, гар бичмэлийн хуралд тус холбооноос 15.000.0 сая төгрөг
- ▶ 2018 оны Японы Шова эмэгтэйчүүдийн Их сургуулийн XX зууны монголын түүх, соёл, хэлний асуудлаар хуралдсан хуралд тус сургуулиас 34.500 орчим доллар
- ▶ 2019 оны 11 сарын БНСУ-ын Үндэсний музейд зохион байгуулагдсан Соёлын өвийн асуудлаарх бүсийн хуралд 56.000.0 сая төгрөгийг Олон улсын Монгол судлалын холбоо олжнийт 14 орны 270 орчим Монгол судлаачдыг хамруулан оролцуулжээ.
- ▶ Жич: эдгээр хуралд Монгол судлалын үндэсний Зөвлөлөөс 40.00.0 сая төгрөгийг зарцуулсан болно.



ОУСМХ-ны удирдлага Япон дахь намрын хуралд

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУСМХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Бүсийн олон улсын хурал



Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУСМХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Mongolica (Монгол судлал), Bulletin (Монгол судлалын мэдээллийн сэтгүүл)-ын хэвлэн нийтлэлт


- ▶ ОУМСХ нь Mongolica (Монгол судлал) хэмээх цэвэр судалгааны чиглэлтэй сэтгүүлийг эрхлэн нийтлүүлж ирсэн. Одоогоор тус сэтгүүлийн нийт 55 дугаар нийтлэгдээд байна. Сүүлийн жилүүдэд уг сэтгүүлийг англи хэлээр нийтлэх болсон бөгөөд олон улсын хянан магадлагаатай сэтгүүл болгохоор манай судлаачид хичээн ажиллаж байна. Бүх өгүүлэлийг гадны эрдэмтэд хянан магадлагаа хийж стандартын дагуу нийтлүүлж эхэлсэн.
- ▶ Bulletin (Монгол судлалын мэдээллийн сэтгүүл)-ыг мөн жилд хоёр удаа нийтлүүлж байгаа бөгөөд эдүгээг хүртэл тасралтгүй нийтлүүлсээр байна. Одоогоор 62 дугаар хэвлэгдсэн болно. Монгол судлалын чиглэлээр Монголд болон дэлхийд болж өнгөрч буй бүхий л мэдээллээс чухлыг сонгон нийтлүүлж дэлхийн бүхий л монгол судлаачдад түгээж байна.
- ▶ Дээрх хоёр сэтгүүлийг тус холбооны вэб хуудсанд бүх дугаарыг цахим болгож байршуулах ажлыг хийж гүйцэтгэж, бүх дугаарын цэсийг үйлдэн тусгай дугаар болгон нийтлүүлсэн.



Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Ном хэвлэл

- ▶ Монгол судлалын сонгодог бүтээл цуврал (Алиса Саркози, Монгол-түвэд-англи Суматирадна толь бичиг, УБ., 2018). Хаадын зарлиг, УБ., 2018.
- ▶ Мөн залуу болон дэлхийд нэртэй эрдэмтэн, монгол судлаачдын ном бүтээлийг хэвлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна.
- ▶ Нийт 241.400.0 сая төгрөгний 21 номыг сүүлийн 5 жилд нийтлүүлсэн байна. Үүний 48.000.0 сая төгрөгийг Монгол судлалын Үндэсний Зөвлөлөөс санхүүжүүлсэн байна.




Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Санаачлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр

- ▶ Гэрэл зураг дахь Монголын түүх цуврал 10 боть. Одоогоор 6 улсад хадгалагдаж буй урд өмнө хэвлэгдээгүй 1750 орчим гэрэл зургийг албан ёсны зөвшөөрөл авч нийтлүүлээд байна.
- ▶ Дэлхийд тархсан өв 20 боть. Одоогоор 8 улсын 14 музей, номын сан, архиваас Монголын холбоотой эд өлгийн зүйлсээс бүрдсэн 12 боть хэвлэн нийтлэгдээд байна.
- ▶ Монгол судлаачдын цахим өв сан хөмрөг бүрдүүлэх төсөл. Одоогоор 7 орны 42 эрдэмтний 60 орчим цагийн бичлэг хийгдээд байна.



Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ФУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

“ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ: БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ, ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ” суурь судалгааны төслийн хүрээнд

- ▶ Нэрт 30 монголч эрдэмтдээс аман түүхийн ярилцлага авч, тусгай сан хөмрөг бий болгосон.
- ▶ Нийт А4 хэмжээний 330 хуудаст бүхий 274 захидал, бичгүүдийг цуглуулж, монгол бичгээр буй баримтуудыг кирил үсэгт буулган хөрвүүлж, орос, англи, монгол хэлээр буй баримтуудыг эмхэтгэв.
- ▶ Монгол судлалын үйл ажиллагаа, монгол судлалын тулгамдсан асуудлуудаар эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулж, боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн. Улмаар энэхүү судалгааны хүрнээнд Монгол судлалын ирээдүйн чиг хандлага, одоогийн нөхцөл байдлыг дүгнэх юм.




ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ



“Гэрэл зураг дахь монголчуудын түүх”

- "Монгол орон ба Монголчууд-I" Монгол улсын анхны Ерөнхий сайдын Оросын эзэнт улсад 1913 оны 10 сараас 1914 оны 2 сар хүртэлх хугацаанд хийсэн төрийн айлчлалтай холбоотой баримт
- "Монгол орон ба Монголчууд-II" Оросын шинжлэх ухааны академийн Хүн судлал, угсаатны зүйн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй XIX-р зууны эцэст хамаарах зураг
- "Монгол орон ба Монголчууд-III" Г.И.Боровкагийн 1925-1926 онд Монголд археологийн судалгаагаар ажилласан үеийн гэрэл зургийн цуглуулга
- "Монгол орон ба Монголчууд-IV" П.К.Козловын Монголд ажилласан сүүпчийн шинжилгээний ангийн түүх (1923-1926)
- "Монгол орон ба Монголчууд-V" Английн дэслэгч Бинстеедийн Монголд зорчсон тэмдэглэл ба гэрэл үүргүүд (1923-1926)
- "Монгол орон ба Монголчууд-VI" Данийн аялагчдын гэрэл зураг, тэмдэглэл.
- "Монгол орон ба Монголчууд-VII" ОХУ-ын Угсаатны зүйн музейн цуглуулга дахь Ухтомскийн цуглуулга
- "Монгол орон ба Монголчууд-VIII" Английн Хааны нийгэмлэгийн номын сангийн цуглуулга

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун



Мэдээллээр хангах



Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Шилдэг Монгол судлал, залуу судлаачын тэтгэлэг

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

- ▶ Жил бүр нэг шилдэг монгол судлаачыг шалгаруулах, цом мөнгөн шагнал олгох ажлыг эхлүүлсэн.
- ▶ Жилд 1-2 залуу судлаачыг Олон Улсын монгол судлалын холбоонд 3 хүртэл сараар хүлээн авч судалгаа хийх дэмжлэг үзүүлэх боломжоор хангах ажлын хүрээнд 6 залуу судлаачыг хүлээж аваад байна.




Монгол Судлалын номын сангийн баяжилт

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

- ▶ ОУМСХ-ны номын сан 6800 орчим ном бүхий хүлээж авсан бөгөөд сүүлийн таван жил 10450 болжнийт 30,000.0 сая төгрөгний 3650 ширхэг номоор баяжилт хийсэн. АНУ-ын монголч эрдэмтэн Денис Вүүдэн гуайн хувийн номын санг тус холбоонд шилжүүлэн авсан.



Мэдээлэл, сурталчилгаа



Монгол судлалын өнөөгийн байдал

- ▶ Өнөөдөр манай холбоонд буй мэдээллээр 17 оронд Монгол судлалтай хамаатай үйл ажиллагааг эрхлэх сургалт судалгааны газрууд ажиллаж байна. Гэхдээ албан ёсны монгол судлалын чиглэлээр ажил алба гүйцэтгэж байгаа нь 260 гаруй судлаач, багш байна.
- ▶ “Монгол судлал” хэмээх тодорхой нэршил бүхий байгууллага тун цөөхөн үлдээд байна. Дэлхийн олон улс орнуудад Монгол судлалыг бүс нутгийн болон тодорхой нэг салбар шинжлэх ухааны хүрээнд авч үзэж байна.
- ▶ Монгол судлалын судалгааны чиглэл, хандлагад ихээхэн өөрчлөлт гарч байна. Монгол улс монгол судлал өөрөө асуудал биш бүс нутгийн болон олон улсын сонирхол татах хандлага бага, томоохон бодлогын судалгаанууд дэлхийн асуудал бүхий улс оронд түлхүү явагдаж байна.
- ▶ Монгол судлалыг дэмжих түүний боломж олгох явдал Монгол улсын хувьд харьцангуй бага ойлголт муу байгаа нь монгол судлалыг хөгжүүлэх боломж бага байна. Тухайлбал, архив, номын сангийн тухай маш буруу хандлага ойлголтыг монголын тодорхой судлаачид улс төрийн асуудал болгож тавьсан юм.
- ▶ Монгол судлалын Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн нь ихээхэн дэвшил авч ирсэн бөгөөд цаашид урт хугацааны болгож хэрэгжүүлэх боломжтой.

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба монгол судлалын өнөөгийн байдал ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, академич С.Чулуун

ДОТООД АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ:БИЧГИЙН БОЛОН АМАН ТҮҮХИЙН САН ХӨМРӨГ
БҮРДҮҮЛЭХ ШИНЭ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

МОНГОЛ БА БҮС НУТАГ



- Евроази
- Зүүн хойд Ази
- Дотоод Ази

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Монгол судлалын цаашдын хандлага чиглэл

- ▶ Дэлхийн олон улс оронд тархсан монгол үндэстний бичиг соёлын өв уламжлалыг бүртгэн судлах, монгол судлалын шинэ залуу үеийг бэлтгэх, гадаадын монгол судлалын төвүүдэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх, монгол судлалын чиглэлээр томоохон бүтээл туурвисан эрдэмтдэд урамшуулал олгох, монгол судлалын мэдээллийг тогтмол, шуурхай түгээх, тодорхой чухал сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулах ажлыг тогтмолжуулах
- ▶ Дэлхийн монгол судлалын эрдэмтэн судлаачдын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл шинээр туурвих, монгол судлаачдыг Монгол улсад ажиллахад тухайн орны нөхцөлөөс дордуулахгүй байдлаар цалинжуулах
- ▶ Урьд өмнө хэвлэн нийтлэгдээгүй шинэ баримт мэдээллийг хэвлэн нийтлүүлэх, монгол судлаач эрдэмтэдтэй хамтран ажиллах, судалгааны цар хүрээг өргөтгөх
- ▶ Монгол улсын судлаачдын хандлага байр суурийг өөрчлөх, ухвар мөчид хандлагыг арилгах, 1990-ээд оноос өмнөх байдлаас ахисан түвшинд оруулах
- ▶ Дэлхийн монгол судлалын хил хязгаарыг тодорхой болгож, бүс нутгийн судалгаануудтай уялдуулан судлах, боловсон хүчнээ энэ хүрээнд боловсруулах цогц бодлого шаардлагатай.
- ▶ “Монгол судлалын ордон” эсвэл томоохон цогц төвтэй болох

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун

Бодлого, үйл ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах

- ▶ Олон улсын судалгааны чиг хандлагад нийцүүлэн судалгааны хэрэгцээ, тэргүүлэх чиглэлээ тогтоох, шинжлэх ухааны тодорхой чиглэлээр буй болгосон үр дүнг янз бүрийн соёлын хүрээнд хуримтлагдсан уламжлалт мэдлэг,орчин үеийн дэвшилтэд технологийн үр дүнтэй хослуулан судлах
- ▶ Дэлхийн өөр улс орнуудын судлалын шинжлэх ухаанд гарсан тодорхой дэвшлүүдийг монгол судлалын хөгжилд хэрхэн авч ашиглах талаар нэгдмэл бодлоготой байх
- ▶ Урт богино хугацааны ирээдүйн талаарх монгол судлалын үнэлгээ, таамаглалыг улам бүр боловсронгуй болгож, 5 жил тутам зохион байгуулагдаж буй хурлаар тусгай салбар болгон хэлэлцүүлдэг болох
- ▶ Монгол судлалыг хөгжүүлэх зорилтыг хангахад улс орон бүрийн оролцоог буй болгохыг зорих ч уламжлалт, тодорхой хүний нөөц, улс төр, эдийн засгийн сонирхол бүхий улсуудад түлхүү анхаарах замаар үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх
- ▶ Хамгийн үр ашигтай тогтвортой мэдлэгийг буй болгох сүлжээний нээлттэй платформыг буй болгох, үр дүнгүй хэрэгжсэн эсэх нь мэдэгдэхгүй төслүүд биш тодорхой үр дүнтэй хамтын ажиллагааг чухалчлан түүний үр дүнгээр төрөөс дэмжлэг үзүүлдэг болгох

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академич С.Чулуун



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Олон Улсын Монгол Судлалын Холбоо ба
монгол судлалын өнөөгийн байдал
ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга,
академигч С.Чулуун

